*Төлөвлөгөөг хянасан:* **Төсвийн Ерөнхийлөн захирагч**

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД С.ЭНХБОЛД /................................/

*Төлөвлөгөө баталсан:* **Төсвийн Шууд захирагч**

АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ц.УРАНЧИМЭГ /................................/

# АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| *№* | *Д/д* | *Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж* | *Төсөв /сая төгрөг/* | *Шалгуур үзүүлэлт* | *Зорилтот түвшин /2022 он/* | *Хугацаа* | *Гүйцэтгэл* | *Хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ЗОРИЛГО 1. ИРГЭДЭД НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРГЭХ | | | | | | | | |
| *Зорилт1.1. Арьс харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлсийг багасгах, харшлын шалтгаант өвчлөл, түүний хүндрэлийг бууруулах* | | | | | | | | |
| 1. | 1.1.1 | МУТЖҮЧ-2.2.2, ЗГҮАХ | 50 | | | | ЭМС-ын 2021 оны А/816 тоот тушаалаар батлагдсан харшлаас сэргийлэх арга | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2.1.1.Харшлаас сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана. | /улсын төсөв/ | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Харшлын сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний нийт 10 ажлыг хэрэгжүүлсэн байна. | Жилийн турш | хэмжээг хэрэгжүүлэх 3 зорилтын хүрээнд нийт 5 ажлыг хэрэгжүүлж ажиллалаа.<br>Орон нутгийн 11 аймгийн 26 мэргэжилтний бүрэлдэхүүнтэй хамтарсан ажлын хэсгийг АӨСҮТ-ийн 2022 оны 06 сарын 03-ны өдрийн А/32 тоот тушаалаар байгуулан, тус орон нутгийн харшил төрүүлэгч ургамлын шинжилгээ, орон нутгийн нөлөөллийн ажлыг зохион байгуулахаар хамтран дараах ажлуудыг 3 зорилтын хүрээнд хэрэгжүүлж ажиллаж байна. Үүнд.<br>1. Харшлаас сэргийлэхэд чиглэсэн бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд Улаанбаатар хот болон аймгуудын ногоон байгууламжид байгаа харшил үүсгэгч ургамлын жагсаалтыг гаргаж, тайрах суурьшлын бүсийн ногоон байгууламжид ашиглах ургамлын талаар заавар боловсруулж, орон нутгийн шийдвэр гаргагч нарт ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулж ажиллаж байна.<br>- Монгол орны зонхилогч 52 нэр төрлийн харшил төрүүлэгч тоост ургамлын нэрсийн жагсаалтыг гаргасан<br>- Хөвсгөл, Орхон, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод аймгуудын нутагт нийт 39 тоост ургамлын нэрсийн жагсаалтыг гаргасан.<br>- Төв, Дундговь, Өмнөговь аймгуудын нутагт нийт 35 тоост ургамлын нэрсийн жагсаалтыг гаргасан<br>Улиасны тоос унгарилын харшлаас сэргийлэх, үетэн шарилж луулийн тоос хүртэлт, үрлэлтийг хадаж тайрах аргаар хязгаарлаж харшлаас сэргийлэх арга технологи сургалтыг орон нутгийн шийдвэр гаргагч хамтарсан ажлын хэсэгт онлайн сургалт явуулсан. Үүнд: | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Улиас модыг хэлбэржүүлэх унгарилын харшлаас сэргийлэх эр эм молцог, баг, цэцэг хяргаж тайрах арга технологи<br>- Шарилж луулийн тоос хүртэлт, үрлэлтийг хадаж тайрах аргаар хязгаарлаж харшлаас сэргийлэх арга технологи<br> <br>Мөн АӨСҮТ нь Zangia.mn мэдээллийн сайттай хамтран МУ-ын ЗГ-ын харшлаас сэргийлэх арга хэмжээний хүрээнд “Ургамлын харшлаас бүх нийтээр сэргийлье” урьдчилан сэргийлэх, олон нийтэд нөлөөллийн үйл ажиллагаа, ургамлын харшлын талаар эрүүл мэндийн зөвлөгөө хүргэж ажилласан. Олон нийтэд нөлөөллийн ажлын хүрээнд: 2022.07.14-2022.09.14-ний хугацаанд зөвлөгөө мэдээллийг шууд дамжуулалт 3, зурган пост 3, ярилцлага 2, видео контент 2 хэлбэрээр хүргэсэн.<br>Харшлын өвчний оношилгоо, эмчилгээг сайжруулахад чиглэсэн бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлж сайжруулах чиглэлээр харшлын арьсан дотор тарих сорилын аргачлал, чонон хөрвөсийн эмнэлзүйн болон хавьтал харшлын дерматитын эмнэлзүйн зааврууудыг харшлын эмч нар боловсруулж батлуулахад бэлэн болоод байна.<br>▪ Чонон хөрвөс өвчнийг илрүүлэх, оношлох, эмчлэх болон хяналтыг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сайжруулах зорилгоор өвчний оношилгоо, эмчилгээнд мөрдөж ажиллах зааврыг боловсруулж батлахад бэлэн болсон.<br>- L50.0 Харшилт чонон хөрвөс<br>- L50.1 Идиопатик чонон хөрвөс<br>- L50.2 Халуун, хүйтний шалтгаант чонон хөрвөс<br>- L50.3 Арьсны зураглаат чонон хөрвөс<br>- L50.4 Чичирхийллийн чонон хөрвөс<br>- L50.5 Холинэргит чонон хөрвөс<br>- L50.6 Хавьтлын чонон хөрвөс<br>- L50.8 Бусад чонон хөрвөс<br>- L50.9 Чонон хөрвөс, тодорхойгүй<br>▪ Хавьтлын харшилт дерматит өвчнийг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, хянах, урьдчилан сэргийлэлтийг сайжруулах зорилгоор хавьтал харшлын дерматит /allergic contact dermatitis/ өвчний оношилгоо, эмчилгээний заавар боловсруулж батлуулахад бэлэн болоод байна.<br>2. Харшлын эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, хүндрэлээс сэргийлэх зорилтын хүрээнд харшил төрүүлэгч ургамлын агаар дахь тоосжилтын хуанлийг боловсруулж, өдөр тутмын цаг агаарын мэдээнд оруулах ажлыг АӨСҮТөвийн харшил судлалын лаборатори, БОАЖЯ, Цаг уур орчны шинжилгээний газар хамтран 2022.04.20-2022.10.05-ны өдрүүдэд Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж эхлээд байна.<br>Судалгааг дараах 6-н бүс нутагт хийлээ: | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 1. Төвийн бүс: Улаанбаатар хотын төвийн 6-н дүүрэг, хот орчим, Налайх, Төв аймгийн Зуунмод хот<br>2. Алтайн бүс: Өвөрхангай (Хайрхандулаан, Нарийн цээл), Баянхонгор (Өлзийт, Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмандал), Говь-Алтай аймаг сумууд<br>3. Баруун бүс: Увс, Ховд, Баян-Өлгий<br>4. Хангайн бүс: Сэлэнгэ, Хөвсгөл, Булган, Архангай, Дархан-Уул, Орхон, Завхан аймгийн төвүүд<br>5. Зүүн бүс: Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн төв<br>6. Говийн бүс: Дундговь, Дорноговь, Өмнөговь, Говьсүмбэр аймгийн төв, зарим сумууд<br>- Улаанбаатар хотын 6-н дүүрэг, цаг уур орчны шинжилгээний мониторингийн цэгүүд, агаарын чанарын хяналтын албаны дээж авах цэгүүдэд зуслангийн бүсийн харшил төрүүлэгч хавар-зуны ургамлын ажиглалт судалгаа хийсэн.<br>- Улаанбаатар хотын 4-н цэгээс агаарын ургамлын тоос тодорхойлох 30-н удаагийн дээж авч микроскопын шинжилгээнд бэлтгэв.<br>- Агаар дахь ургамлын тоосжилт үүсэх зүй тогтол, тоосжилтын хэмжээ, өдөр сар улирлын тархалтын тоо, хөдлөл зүй тогтоох, аэропалинологийн судалгааг өргөжүүлж, хот аймгуудыг агаарын тоосжилтын хуанлитай болгох зорилгоор агаараас ургамлын тоос баригч 12 ширхэг Дюрама аппаратын шинэчилсэн загвар зохиож үйлдвэрлүүлсэн. Улаанбаатар хотод 3-н цэгт аймаг сумдын төвд тус тус | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 1 ширхгийг байрлуулж агаарын дээж бэлтгэсэн.<br>- Агаарын ургамлын тоосжилтыг хянаж мэдээлэх нэгдсэн систем бий болж тоосжилт эхлэх үе түүний оргил үе, дуусах үеийг иргэдэд мэдээлэх лайв хийж олонд мэдээлж улиасны тоос, унгарилын тархалтыг хязгаарлах, харшил төрүүлэгч үетэн ба хөл газрын ургамлын агаар дахь тоосжилтыг хадаж тайрах аргаар багасгах арга технологи батлуулж практикт нэвтрүүлэв<br>- Орхон Булган, Хөвсгөл, Баянхонгор, Өвөрхангай, Хэнтий, Дорнод, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ зэрэг аймгуудын агаарын тоосжилтын хуанлитай болгох ажлыг эхлүүлж Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотууд, Сэлэнгэ аймгийн агаарын тоосжилтын хуанлийг боловсруулав.<br>- Агаар дахь ургамлын тоосны овог төрлийн бүрэлдэхүүн, хөрсний өнгөн хэсгийн ургамлын тоосны агууламжаар хот суурин газрууд эдийн засгийн бүс нутгаар өвчлөл үүсэх нөхцөлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх өвөрмөц аллерген эмчилгээ хийх, цаг хугацааг заасан хуваарь бүхий хуанли гаргав.<br>- Монгол орны агаарын ургамлын тоос тодорхойлж таних хялбарчилсан зурагт түлхүүр бичиг зохиов.<br>- Агаарын ургамлын тоосжилтын судалгааг цаг уурын үзэгдэл, ургамлын цэцэглэлтийн хугацаа, эмнэлэгт үзүүлэгчдийн тоо, давтамж зэрэгтэй холбон судалсан ажлын үр дүнг нэгтгэж харшлаас сэргийлэх зөвлөмж | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсруулж зурагт хуудас нугалбар танилцуулгатай болов.<br>- Эмч мэргэжилтнүүд, иргэдийн эрүүл мэнд экологийн боловсролд зориулсан Монгол орны харшил төрүүлэгч тоост ургамал танин мэдэхүйн гарын авлага зохиож хэвлүүлж байна<br> <br>3. Харшлын өвчний оношилгоо, эмчилгээний менежментийг боловсронгуй болгож, хүндрэлийг бууруулах зорилтын хүрээнд атопийн дерматитын хяналтын зааврыг боловсруулах, хүндрэл сэдрэлээс сэргийлэх зорилгоор 14 хуудас эмнэлзүйн зааврын төсөл 2022.12.20-ны өдөр эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэхэд бэлэн болсон<br>"Орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд арьс харшлын зонхилон тохиолдож буй харшлын ринит, ургамлын харшил, эмийн бодисоос улбаалсан арьсны түгмэл тууралт, хордлого харшлын дерматит зэрэг өвчлөл, тэдгээрийн оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга, арьс харшлын өвчнийг хянах, орчин үеийн эмчилгээний чиг хандлагын талаарх мэдлэг, ур чадвар, хандлагад сургах, дадлагажуулах зорилгоор "Зонхилон тохиолдож буй | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | арьсны өвчнүүдийн орчин үеийн эмчилгээний чиг хандлага, урьдчилан сэргийлэлт ” сэдэвт 1 багц цагийн сургалтыг Өмнөговь аймагт зохион байгууллаа. Сургалтыг АӨСҮТ-ийн ЭЭДЗ Б.Батцэцэг /АУ-ны магистр, ахлах зэргийн эмч/ Поликлиникийн тасгийн эрхлэгч Г.Цогзол/АУ-ны магистр, зөвлөх зэргийн эмч/ нар удирдан явууллаа. | |
| 2. | 1.1.2 | МУТЖҮЧ-2.2.2. Үйлчлүүлэгчдэд арьс, харшлын чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил хийх, гарын авлага боловсруулан түгээнэ. | 1 /өөрийн орлого/ | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Арьс харшлын чиглэлийн нийт 30 сэдвээр 10000 хүнд мэдээлэл хүргэж ажилласан байна. | Жилийн турш | Арьс, харшлын нийт эмч нараар иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох хуваарийн дагуу нийт 20 ярилцлага, 2 нийтлэл, 2 контент хийж олон нийтийн эрүүл мэндийн боловсрол олгох нөлөөллийн ажлуудыг зохион байгуулсан. Нийт 16,000 иргэдэд эрүүл мэндийн зөвлөгөөг өгч, 500 гаруй мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудас болон пэйж хуудаст нийтэлсэн. Үүнд:<br>1. Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирал, АУ-ны магистр, клиникийн профессор, тэргүүлэх зэргийн эмч Ц.Уранчимэг ЭМЯ-ны хэвлэл мэдээллийн албанаас эрхлэн явуулдаг Live мэдээллийн сувгаар харшлаас урьдчилан сэргийлэх болон харшил сэдэрсэн үед авах арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлэл хүргэв.<br><br> | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2. Харшлын өдөөж халдвар тараах эрсдэлт нөхцөлийг бүрдүүлдэг улиасны унгарилын талаар мэдээллийг АӨСҮТ-ийн харшил судлалын лабораторийн эрхлэгч ШУ-ны доктор Б.Сангидорж олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, телевизээр шууд ярилцлагыг хүргэсэн.<br><br><br>3. “Харшилтай тэмцэх дэлхийн өдөр”-ийн хүрээнд арьсны зөвлөх эмч А. Байгалмаа бага насны хүүхдүүд муур, нохойноос мөөгөнцрийн халдвар ихсэж байгаатай холбоотой олон нийтэд мэдээлэл хүргэсэн.<br><br><br>4. Арьс, харшлын их эмч Б.Энхсайхан ургамлын харшил болон чонон хөрвөс өвчний талаар иргэдэд мэдээлэл хүргэсэн. | |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>



5. Арьс харшлын өвчинд үзүүлэх архины хор нөлөө сэдвээр их эмч Н.Ням-олдох иргэдэд хийж байгууллагын пэйж болон амбулаторийн ТВ-гээр дамжуулан мэдээлэл хүргэлээ.




6. Арьсны хавдраас урьдчилан сэргийлэх талаар ЭМТҮЧАБАлбаны дарга Б.Баярмаа мэдээлэл хүргэв.


Арьс өвчин судлалын үндэсний төвийн ЭМТҮЧАБАлбаны дарга, арьсны өхлах зэргийн эмч Б.Баярмаа
</td><td></td></tr>
</table>

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>
7. 7,8-р сард шарилжийн харшил идэвхэждэг тул харшилтай хүмүүс айраг уухгүй байх талаар Арьс харшлын их эмч Д.Мөнгөнтүлхүүр zarig.mn сайтаар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэж 5000 хүний хандалт авч 50 лайк, 30 шейрлэгдсэн




8. 2022 оны 8 сард Zaag.mn сайтын “Эмч зөвлөж байна” дугаарт АӨСҮТ-ийн их эмч Б.Энхсайхан харшлын сорилын талаар мэдээлэл хүргэж 13127 хүний хандалт авч 50 лайк, 42 шейрлэгдсэн.




9. Арьсны өвчин судлалын үндэсний төв”-ийн Эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн тасгийн арьс харшлын эмч У.Саруул чонон хөрвөс өвчин, хайрст үлд өвчний талаар zindaa.mn сайтад
</td>
<td></td>
</tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ярилцаж, зөвлөгөө мэдээллийг хүргэж 51475 хүний хандалт авч 188 лайк, 173 шейрлэгдсэн<br><br><br>10. АӨСҮТ-ийн их эмч Б.Номин хатиг арга хэмжээ, MRSA болон ижил төстэй идээт үрэвслээс ялган оношлох, урьдчилан сэргийлэхийн тулд юуг анхаарах талаар zaag.mn сайтад мэдээлэл хүргэж 13240 хүний хандалт авч 44 лайк, 47 шейрлэгдсэн<br><br><br>11. АӨСҮТ-ийн клиникийн 1-р тасгийн их эмч С.Солонго "Ягаан батганы талаар zaag.mn сайтад мэдээлэл хүргэж 12009 хүний хандалт авч 43 лайк, 25 шейрлэгдсэн. | |

<table>
<tr>
<td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td>
<td>



12. АӨСҮТ-ийн Клиникийн II тасгийн их эмч, АУ-ны магистр С.Билгүүнцоож "Хүн амын дунд ихээхэн тохиолддог түүхий өвчний талаар мэдээлэл хүргэж 15336 хүний хандалт авч 80 лайк, 48 шейрлэгдсэн.




13. АӨСҮТ-ийн поликлиникийн тасгийн их эмч Х.Энхжин псориаз буюу хайрст үлд өвчний талаар zaag.mn сайтад мэдээлэл хүргэж 17160 хүний хандалт авч 65 лайк, 69 шейрлэгдсэн
</td>
<td></td>
</tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | <br><br>14. АӨСҮТ-ийн арьс гоо заслын их эмч О.Урангоо Арьсны халдварт мөөгөнцөрт өвчний талаар zaag.mn сайтад мэдээлэл хүргэж 3386 хүний хандалт авч 40 лайк, 6 шейрлэгдсэн<br><br><br>15. АӨСҮТ-ийн арьсны мэс засал, эмчилгээний гоо заслын их эмч Д.Сүхболд арьсны хортой болон хоргүй хавдрын талаар zaag.mn сайтад мэдээлэл хүргэж 7318 хүний хандалт авч 30 лайк, 17 шейрлэгдсэн. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | <br><br>16. АӨСҮТ-ийн Хүүхдийн тасгийн их эмч Н.Золбаяр MRSA халдварын талаар мэдээлэл хүргэж 3527 хүний хандалт авч 42 лайк, 18 шейрлэгдсэн.<br><br><br>17. АӨСҮТ-ийн насанд хүрэгчдийн арьсны эмгэг судлалын 2-р тасгийн эрхлэгч Ж.Аззаяа эмийн харшлын талаар мэдээлэл хүргэж 5002 хүний хандалт авч 48 лайк, 18 шейрлэгдсэн. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | <br>18. АӨСҮТ-ийн поликлиникийн их эмч Д.Ганбаяр Бүслүүр үлд өвчний талаар мэдээлэл хүргэж 3500 хүний хандалт авч 35 лайк, 15 шейрлэгдсэн.<br><br>19. 2022 оны 5 сарын 4-ны өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын 24-р сургуулийн 8-р ангийн 45 сурагчдад “Өсвөр насны арьс арчилгаа” сэдвээр их эмч Б.Номин, Х.Хэрлэн /НЭМА/ нар хамтран сургалт зохион байгуулж сургалтаар арьс, харшлын өвчний талаар гарын авлагыг иргэдэд тараасан.<br> | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 20. Тасгийн эрхлэгч Г.Баянжаргал ETV-ийн өсвөр насны хүүхдийн нэвтрүүлэгч “Батга болон өсвөр насны хүүхдүүдийн арьс арчилгаа” сэдвээр, 10 сарын 18-нд МҮОНРТ-ийн “Өдрийн хөтөлбөр”-т батга өвчний талаар ярилцлага өгсөн.<br>21. Ургамлын тоосны харшлаас урьдчилан сэргийлэх талаар 2 төрлийн гарын авлага боловсруулж, видео бичлэг хийж байгууллагын пэйж хуудсаар дамжуулан түгээж иргэдэд мэдээлэл түгээсэн.<br>22. Эрүүл мэндийн сайдын санаачилгаар 2022 оны 06 сарын 12-ны өдөр зохион байгуулсан "Эрүүл мэндийнхээ төлөө - Алхангаа ярилцъя" аяны хүрээнд арьс, харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл идэвхтэй амьдралыг хэвшүүлэх, түүнчлэн дасгал хөдөлгөөний ач холбогдлын талаар иргэдэд мэдээлэл хүргэж ажиллалаа. Уг арга хэмжээний үед 10 төрлийн гарын авлага, мэдээллийг өнгөтөөр бэлтгэн мэдээлэл бүрийг багтаасан багц байдлаар бэлдэж, үйл ажиллагаанд оролцсон байгууллагууд, олон нийтэд түгээж, арьсны өвчин, харшлын талаар эрүүл мэндийн зөвлөгөөг газар дээр нь өгч үр дүнтэй ажиллалаа. Үйл ажиллагааны үеэр нийт 200 ширхэг гарын авлага түгээсэн, 150 хүнд газар дээр нь арьсны өвчний талаарх зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |  <br>23. Шарилжийн цэцгийн тоосны харшлаас сэргийлэх өвөрмөц уусмал хэрэглэх заавар, ургамлын тоосны харшил зэрэг 2 видеог байгууллагын фейсбүүк болон амбулаторийн дэлгэцээр тогтмол явуулж байна. | |
| 3. | 1.1.3 | МУТЖҮЧ-2.2.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын тандалт судалгааг хийнэ. | 0.2 /өөрийн орлого/ | Судалгааны тайлан | Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын тандалт судалгааг хийж, гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. | Жилийн турш | ➢ Тасгууд тарилгын иж бүрдэл болох мөөгөнцөрт өвчний иж бүрдэл, уян зүүний иж бүрдэл, өртөлтийн иж бүрдлийг бүрдүүлж эмчилгээ үйлчилгээндээ хэрэглэж байна. 2022 оны байдлаар нийт 3 өртөлт бүртгэгдсэн.<br>1. ЭГЗНСТ-ийн сувилагч мэс ажилбар хийх явцад мэс заслын сувилагч оёдлын утасны зүүнд хатгуулсан тохиолдол гарсан тул өртөлтийн хуудсыг бөглүүлж, үйлчлүүлэгчээс шинжилгээ авч яаралтай хариу арга хэмжээ авсан. 3 сарын дараа давтан шинжилгээ авахад ямар нэгэн цусаар дамжих халдвар илрээгүй байна.<br>2. Лабораторийн тасгийн ариутгагч бактериологийн шилэнд хуруугаа гэмтээсэн тохиолдол гарсан тул шархыг ариутгаж, цэвэрлэх, халдвараас сэргийлэх арга хэмжээг яаралтай авч, 3 сарын дараа давтан шинжилгээнд хамрагдсан байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 3. Эрчимт эмчилгээ яаралтай тусламжийн тасгийн ахлах сувилагч шинжилгээний зүүнд баруун гарын эрхий хурууны хумсны ирмэг хэсэгт хатгуулсан. Өртөлтийн хуудсыг бөглүүлж, үйлчлүүлэгчээс шинжилгээ авч яаралтай хариу арга хэмжээ авсан. Эмнэлгийн ажилтнаас гепатит в болон с вирусийн шинжилгээг авсан.<br>➢ Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын тоо мэдээг ХӨСҮТ рүү тогтмол мэдээлж байна. 2022 оны байдлаар нийт хатгалт 68126, дундаж хатгалт 2.3, арьсан дор 0.4, булчин 1, судас тариа 0.7, дусал тариа 1.3 байна.<br>➢ Ариутгал болон устгал тэжээлийн автоклавт 1 CLASS-4 тестээр долоо хоног бүр автоклавыг шалгадаг. Өдөр бүр энгийн хяналтын тестээр ариутгал болон тэжээлийн автоклавыг зөв ажиллаж байгааг шалгадаг. Ариутгалын хэсэгд 2 автоклаваар ариутгал хийдэг бөгөөд ариутгал хийх болгонд химийн индикатораар нааж багаж, тоног төхөөрөмж хөвөн, бусад ариутгалд ирдэг бүх материал дээр индикатор нааж хянадаг.<br>➢ Medclean ХХК-тай хамтран “Арьсны өвчин судлалын үндэсний төвийн”-ийн ариутгалын автоклавт bag-biocheck био-индикаторын нийт 4 удаа сорил тавьж шалгуулсан. Шалгалтын дүнд автоклавын ажиллагаа хэвийн, хэмжилт хийсэн өдрийн байдлаар спор бүрэн устгагдсан байна. | |




- 2022 онд улирал тутамд арчдасын ариун чанар болон агаарын ариун чанарын шинжилгээг авч халдвараас сэргийлэх дотоод хяналтыг хийж ажилласан. АӨСҮТ-ийн дотоод халдварыг илрүүлэх зорилгоор 262 ширхэг арчдасны шинжилгээ авсан байна.

  1-р дүгээр улиралд 72 ширхэг арчдасны ариун чанарын шинжилгээ авсан. Үүнээс:
  1. Ургалтгүй-75% /54/
  2. Staphylococcus spp-13.8% /10/
  3. S.aurues-5.5% /4/
  4. Enterococcus-4.6% /3/ ургасан байна.

  2-р улиралд 70 ширхэг арчдасны ариун шинжилгээ авсан ба үүнээс:

  1.Ургалтгүй-88.5% /62/
  2.Staphylococcus spp-5.7% /4/
  3.S.Aurues-5.7% /4/ ургасан

  3-р улиралд 70 ширхэг арчдасны ариун шинжилгээ авсан ба үүнээс:
  1. Ургалтгүй-96% /48/
  2. Staphylococcus-18.5% /13/
  3. S.aureus-12.8% /9/

  4-р улиралд 50 ширхэг арчдасны ариун шинжилгээ авсан ба үүнээс:
  1. Ургалтгүй-90% /45/
  2. Staphylococcus spp-8% /4/
  3. S.aurues-2% /1/

Цаашид цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах, эмнэлгийн дотоод халдвараас сэргийлж, хяналт тавьж ажиллаж байна.

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ЗОРИЛГО 2. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАСРАЛТГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ | | | | | | | | |
| *Зорилт 2.1. Арьс харшил, эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах* | | | | | | | | |
| 4. | 2.1.1 | МУУХХБ-2.2.11, ЗГҮАЧ-2.1. Үйлчлүүлэгч утсаар цаг товлох, зөвлөгөө мэдээлэл авах үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллана. | - | Утсаар цаг товлох үйлчилгээ авсан хүний тоо Утсаар зөвлөгөө авсан хүний тоо | Утсаар цаг товлох үйлчилгээ болон зөвлөгөө мэдээлэл авсан үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлсэн байна. | Жилийн турш | 2022 оны байдлаар утсаар болон цахимаар цаг товлох үйлчилгээг 115914 үйлчлүүлэгч нарт үзүүлсэн байна. Цаг товлосон иргэдтэй утсаар урьдчилан холбогдож баталгаажуулах үйлчилгээг шинээр нэвтрүүлснээр 54577 үйлчлүүлэгчтэй холбогдож цаг товлолыг баталгаажуулан, 8600 цаг товлолыг урьдчилан цуцалсан.<br>Цахим бүртгэлд 61337 үйлчлүүлэгч, утсаар 54577 үйлчлүүлэгч цаг товлох үйлчилгээнд хамрагдсан байна. Цаг цуцалсан иргэдийн оронд шинээр цаг авахаар хүлээж буй үйлчлүүлэгчдийг бүртгэж тусламж үйлчилгээг түргэн шуурхай хүргэж ажиллаж байна. | 100 |
| 5. | 2.1.2 | МУТЖҮЧ-2.2.3, ЗГҮАЧ-2.1. Амбулаторийн кабинетуудын төрлийг нэмэгдүүлнэ. /дотрын кабинет, дүрс оношилгооны кабинет, арьс харшлын кабинет/ | 10 /улсын төсөв/ | Шинээр байгуулсан кабинетаар үйлчлүүлэгчийн тоо | Дотрын болон дүрс оношилгооны кабинет шинээр байгуулагдаж үйл ажиллагаа тогтмолжсон байна.<br>Арьс, харшлын кабинетын тоог 1-ээр нэмэгдүүлсэн байна. | Жилийн турш | Амбулаторид нийт 16 кабинет ажиллаж тусламж үйлчилгээг үзүүлж байна.<br>➢ Дүрс оношилгооны кабинетыг шинээр байгуулж иргэдэд тусламж үйлчилгээг үзүүлж байна. ЭМЯ, ДЭМБ-ын санхүүжилтээр Хятад Улсад үйлдвэрлэгдсэн, Mindray зөөврийн 4 төрлийн дамжуулагч /probe/, суурь, хэвлэгч бүхий иж бүрэн эхо аппаратыг төвд хүлээлгэн өгсөн. Дүрс оношилгооны эмч Б.Лхагвасүрэн 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс нийт 373 үйлчлүүлэгчдэд арьс, бамбай булчирхай, цуллаг эрхтэн, түрүү булчирхайн хэт авиан оношилгоо шинжилгээг хийж, тусламж үйлчилгээг үзүүлээд байна. АӨСҮТ-ийн ажилтнуудын урьдчилан сэргийлэх үзлэг 2 удаа хийсэн. Үүнд: | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Эрэгтэй ажилтны үзлэгт 19<br>- Ахмад ажилтны үзлэгт 15 хүн хамрагдсан<br>- Гэрээр 1 (90 настай ахмад эмч) үзлэг хийсэн<br>Кабинетад хийгдэж буй оношилгооны төрөл:<br>- Арьс, арьсан доорх эд, жижиг хэсэг<br>- Цуллаг эрхтэн<br>- Бамбай булчирхай<br>- Түрүү булчирхайн хэт авиа<br>Илэрсэн өөрчлөлтийн бүтэц<br>1. Элэгний өөхжилт, хатуурал 180<br>2 .Нойр булчирхайн өөхжилт, архаг үрэвсэл 105<br>3. Элэг/Бөөрний уйланхай 46<br>4. Бамбай булчирхайн голомтот өөрчлөлт 24<br>5. Цөсний хүүдийн чулуу 21<br>6. Түрүү булчирхайн томрол 11<br>7. Липома 8<br>8. Бөөрний чулуу 5<br>9. Целлюлит 3<br>10. Миома 3<br>11. Элэгний хавдар 2<br> <br>Коронавирусын халдвартай өвчтөнүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх зорилгоор нэмэлтээр 40 орыг нэмэлтээр дэлгэж ажиллуулсантай холбоотой 2022.01.19 - 2022.02.08-ны хугацаанд хооронд | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | цээжний эгц байрлалд авсан 106 цээжний рентгенээр оношлогоо шинжилгээ хийсэн. Цээжний эгц байрлалд:<br>1. Гуурсан хоолойн архаг үрэвсэлт өөрчлөлт (ковидын дараах өөрчлөлт)-54<br>2. Вирусний хатгалгаа (захад байрласан нэвчдэст сүүдэр)-14<br>3. Зүрхний зүүн ховдлын нумын томрол -21<br>4. Уушгины шохойжилт (голомтот)-7<br>5. Цээж нурууны кифосколиоз-4 оношлосон.<br>➢ Харшлын кабинетын тоог 2 дахин нэмэгдүүлж нийт 4 кабинет иргэдэд тусламж үйлчилгээг үзүүлж ажиллаж байна.<br>➢ Арьсны кабинетын тоог 2-оор нэмэгдүүлж нийт 10 кабинет иргэдэд тусламж үйлчилгээг үзүүлж ажиллаж байна.<br>➢ Арьсны мэс заслын кабинет тусламж үйлчилгээг үзүүлж байна. Амбулаториор мэс ажилбар хийлгэсэн -36 үйлчлүүлэгч, өдрийн эмчилгээнд хамрагдаж мэс засал хийлгэсэн үйлчлүүлэгчийн тоо 7 байна. | |
| 6. | 2.1.3 | МУТЖҮЧ-2.4.1, ЗГҮАХ-1.1.3. Коронавирусын халдвартай өвчтөнд тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлнэ. | 20 /өөрийн орлого/ | Хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчээс гарсан гомдол санал | Коронавирусын халдвартай өвчтөнд тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлсэн байна. | Шаард-лагатай үед | 2022 оны 01 сарын 12 өдрийн Гүйцэтгэх захирлын А/16 дугаар тушаалын дагуу коронавирус халдвартай иргэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх 40 орыг 2022 оны 1 дүгээр сарын 17-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 14-ны өдөр хүртэлх хугацаанд дэлгэж 6 хүний бүрэлдэхүүнтэй эмч, эмнэлгийн ажилчдын баг ээлжээр ажиллаж нийт 71 өвчтөнд тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж ажилласан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | 2.1.4 | МУТЖҮЧ-2.2.3, БДХСТ-5.1.1.6. Эмчилгээний гоо засал, нөхөн сэргээх тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ. | 20 /улсын төсөв/ | Үзүүлсэн тусламж үйлчилгээний нэр төрөл, тоо | Эмчилгээний гоо засал, нөхөн сэргээх чиглэлээр 17 нэр төрлийн тусламж үйлчилгээг үзүүлдэг болсон байна. | Жилийн турш | Эмчилгээний гоо заслын чиглэлээр нийт 3 төрлийн үйлчилгээг нэвтрүүлээд байна.<br>1. АӨСҮТөвийн ЭГЗНСТасаг нь БНСУ-ын KFDA -р зөвшөөрөгдсөн GMP, ISO шалгуур хангасан нүүр өргөх PLLA, PDO утас, дүүргэгч утас зэргийг эмчилгээний практикт ашиглаж эхэллээ.<br>- Нүүрэнд утас суулгах мэс ажилбарыг нийт 14 удаа хийсэн. 1-2 жилийн хугацаатай PLLA, PDO өргөстэй утсаар арьсыг өргөх, коллагены нийлэгжилтийг нэмэгдүүлэх ажилбар 5 удаа хийж гүйцэтгэсэн<br><br><br>- PDO өргөстэй утсаар хөмсөг өргөх, коллагены нийлэгжилтийг нэмэгдүүлэх ажилбар 2 удаа<br><br><br>- PDO өргөстэй утсаар хамрын нурууны хэлбэр засах, коллагены нийлэгжилтийг нэмэгдүүлэх ажилбар 1 удаа | 100 |

<table>
<tr>
<td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td>
<td>



- PDO дан өргөсгүй утсаар хялгасан үрчлээ арилгах, коллагены нийлэгжилтийг нэмэгдүүлэх ажилбар 4 удаа
- PDO мушгиа утсаар арьсны гүн үрчлээ үүссэн хэсэгт дүүргэлт 2 удаа

Нүүрний арьсанд утас суулгах мэс ажилбарын дараах хүндрэл, эрсдэлийн тоо:<br>
Хоёрдогч халдвар, соривжилт, нүүрний мэдрэл гэмтэх гэх мэт хүндрэл гараагүй.<br>
Жижиг судас хагарснаас үүссэн хөхрөлт– 5<br>
14 хоног хүртэлх өвдөлт – 6<br>
Утас суулгасан хэсэгт үүссэн хаван – 8<br>
Хонхорхой, жигд бус байдал – 3

2. Их эмч Д.Сүхболд арьс цайрах өвчний үед арьс шилжүүлэн нөхөх, жижиг хэмжээний хоргүй хавдрыг мэс заслын аргаар авах ажилбарыг амжилттай нэвтрүүлээд байна. Арьс цайх өвчний үеийн *Punch graft* мэс заслыг 4 өвчтөний арьс цайлттай 11 байрлалд мэс засал хийгдсэн.





Арьс цайх өвчний үеийн Punch graft мэс заслын дараах хүндрэл, эрсдэлийн тоо:
</td>
<td></td>
</tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - донор ба хүлээн авагч хэсэгт хоёрдогч халдварын хүндрэл гараагүй.<br>- хүлээн авагч хэсэгт булшны чулууны шинж үүсэлт – 2<br>- хүлээн авагч хэсэгт эргэн нөсөөжилт үүсэхгүй байх – 5<br>Хэт ургалттай соривжилтний Z plasty мэс заслын дараах хүндрэл, эрсдлийн тоо:<br>- хоёрдогч халдварын хүндрэл гараагүй<br>- дахин ургалттай соривжилт үүссэн байдал – 1<br>- мэс заслын дараах хөхрөлт – 3<br>3. Хэт ургалттай соривжилтний Z plasty мэс заслыг 4 удаа хийсэн. Нүүрний байрлалтай 1, өвчүүний харалдаа байрлал 2, суганы доод хэсгийн байрлал 1 удаа хийсэн байна.<br> | |
| 8. | 2.1.5 | МУУХХБ-2.2.11. Өдрийн эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | - | Өдрийн эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо | Өдрийн эмчилгээнд 550 үйлчлүүлэгч хамрагдсан байна. | Жилийн турш | 2022 оны байдлаар нийт 480 өвчтөн өдрийн эмчилгээнд хамрагдаад байна. Өмнөх онтой харьцуулахад 51 хувиар өссөн байна. Харшлын сорил 4314, плазмаферез 92, аутосерум 616 хийсэн.<br>Зонхилон тохиолдох өвчнөөр атопийн дерматит, хайрст үлд, архаг экзем, чонон хөрвөс, мөөгөнцөр оношоор эмчилгээнд хамрагдаж байна. Дундаж ор хоног-8, эмчилгээний дундаж зардал 42682₮ байна.<br>Поликлиникийн тасгийн болон өдрийн эмчилгээний сувилагч нар сувилахуйн чиглэлээр Бехчет өвчний оношилгоонд “Хэт мэдрэгшлийг үзэх патэргийн сорил”-ыг шинээр тавьж эхэлсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |  | |
| 9. | 2.1.6 | ЗГҮАХ-2.1.4.4. Эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй үзүүлнэ. | - | Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн хувь | Эрчимт эмчилгээ, яаралтай тусламж шаардлагатай үйлчлүүлэгчдэд тусламж, үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй үзүүлсэн байна. | Жилийн турш | Яаралтай тусламжаар нийт 4094 үйлчлүүлэгчдэд тусламж үйлчилгээг үзүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 26.6 хувиар өссөн байна<br>Эрэмбээр:<br>- Улаан 13,<br>- Шар 1071,<br>- Ногоон 2596,<br>- Цагаан 414<br>Өвчлөлийн төрлөөр:<br>- зүрх судас 22,<br>- арьсны замын өвчин 1514,<br>- харшлын өвчин 2558<br>Шийдвэрлэсэн байдлаар:<br>- Ажиглалт 322,<br>- ЭЭТд хэвтсэн 26,<br>- Бусад тасагт хэвтсэн 28,<br>- буцсан 1941.<br>Эрчимт эмчилгээнд нийт 179 хүн хэвтэн эмчлүүлсэн ба үүнд хурц чонон хөрвөс, дотуур хэрэглэсэн бодисын шалтгаант дерматит, олон хэлбэрт эритем, цэврүүтэлт, лайеллын хам шинж , ангионеврозын хаван, эм буюу эмийн бэлдмэлийн тодорхойгүй гаж нөлөө зонхилон тохиолдож байна.<br>➢ Энгийн цэврүүтэлт оноштой хүнд Ритуксимаб эмчилгээг хийж эхлээд байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Европын арьс болон бэлгийн замын өвчний академийн 2020 оны шинэчлэгдсэн жинхэнэ цэврүүтэлтийн guideline-ы дагуу ритуксимабыг эхний 2 удаад цохилтын тунгаар 1000мг/100мл, NaCl 0.9%-100 мл шингэлж пампаар, 2 долоо хоногийн зайтай хийсэн болно.<br>  | |
| 10. | 2.1.7 | МУТЖҮЧ-2.2.3. Лабораторийн шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ. | 15 /өөрийн орлого / | Шинээр нэвтрүүлсэн лабораторийн шинжилгээний нэр, төрлийн тоо | Лабораторийн 25 нэр төрлийн оношилгоо, шинжилгээг хийдэг болсон байна. Аллерген өвөрмөц дархлаа эмчилгээний бэлдмэлийг 25 хувиар нэмэгдүүлсэн байна. | Жилийн турш | Шинжилгээний нэр төрлийг 2-оор нэмэгдүүлсэн. Үүнд:<br>1. 2022 оны 4 дүгээр сараас коагулаграммын хагас автомат Biobase аппаратаар дараах 4 үзүүлэлтээр нийт 123 хүнд шинжилгээг хийсэн байна:<br>- APTT - 123<br>- PT - 123<br>- FIB - 123<br>- TT - 123<br><br>2. Radia immuno аппаратыг суурилуулснаар прокальцитониныг үзүүлэлтийг 12 дугаар сараас шинжилж эхэлсэн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |  | |
| 11. | 2.1.8 | ЗГҮАХ2.1.4.2. Зориулалтын тоноглогдсон автомашинтай болно. | 60 /улсын төсөв/ | Шинээр авсан автомашин | Зориулалтын тоноглогдсон автомашинтай болсон байна. | Жилдээ | Эмнэлгийн зориулалтын автомашинаар хангаж өгөх талаар саналыг ЭМЯ-нд хүргүүлсэн.<br>Шаардлагатай үед эмнэлгийн зориулалтын тоноглогдсон автомашинаар өвчтөнийг эмнэлэг хооронд тээвэрлэх гэрээг "Сувд Буян" ХХК-тай 2022 оны 01 дүгээр сард байгуулсан. | 50 |
| ЗОРИЛГО 3.ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ | | | | | | | | |
| *Зорилт 3.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоо, арга хэрэгслийг сайжруулан, тасралтгүй байдлыг хангах* | | | | | | | | |
| 12. | 3.1.1 | МУТЖҮЧ-2.2.3. Арьсны өвчний оношилгоо, эмчилгээний нийт 10 эмнэлзүйн заавар, арга аргачлал боловсруулж батлуулна. | - | Батлагдсан эмнэлзүйн заавар, арга аргачлалын тоо | Арьсны өвчний оношилгоо, эмчилгээний нийт 10 эмнэлзүйн заавар, арга аргачлал батлуулсан байна. | Жилийн турш | Арьсны өвчний оношилгоо, эмчилгээний нийт 8 эмнэлзүйн заавар, 2 арга аргачлал боловсруулаад байна.Үүнд:<br>➢ Хавьтал харшлын дерматит, цэлцрүүт пемфигойд, хордлого харшлын дерматит, хатиг мундас, олон хэлбэрт шүүдэст улайрал, ягаан үлд, жинхэнэ цэврүүтэлт, чонон хөрвөс өвчний эмнэлзүйн зааврыг арьс, харшлын эмч нар боловсруулж АӨСҮТ-ийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр товлогдсон байгаа.<br>➢ Келойд сорвийг мэс заслын аргаар эмчлэх, арьс цайх өвчнийг мэс заслын аргаар эмчлэх, 2 арга аргачлалыг боловсруулж АӨСҮТ-ийн эмнэлзүйн багаар хэлэлцүүлж 5 өвчтөнд хийгээд байна.<br>➢ Арьс гоо заслын гардан үйлдлийн жагсаалт, стандартыг Арьс судлаачдын Монголын нийгэмлэг, ЭМЯ-тай хамтарсан | 80 |

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>ажлын хэсэгт оролцон хамтран боловсруулж ЭМЯ-д хүргүүлээд байна.<br>➢ 2022 оны “Эрүүл мэндийн салбарын чанар, аюулгүй байдлын жил” болгон зарласантай холбоотойгоор ЭМЯ-ны ажлын хэсгээс стандартад тусгах түгээмэл үйлдлийн жагсаалтад санал авахад саналаа хүргүүлсэн. Үүнд:<br>1. Арьс, салст, арьсны дайврын эмгэгийг үзэж шинжлэх аргад-18<br>2. Эмчилгээний гоо заслын үйлдлийн стандарт-6 бүлэг, 23 төрөл<br>3. Арьсны оношилгоо, шинжилгээний үйлдлийн стандарт-13<br>Өргөдөл гомдол, сэтгэл ханамжийн үнэлгээтэй холбоотой 2 журам шинээр батлуулан мөрдөн ажиллаж байна:<br>1. АӨСҮТ-өөр үйлчлүүлж буй хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ хийх журам<br>2. Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авах шийдвэрлэх, хяналт хийх журам</td>
<td></td>
</tr>
<tr>
<td>13.</td>
<td>3.1.2</td>
<td>МУТЖҮЧ-2.2.7, ЗГҮАХ–2.1.8 Эмч, эмнэлгийн ажилчдын Uptodate олон улсын эмнэлзүйн удирдамжийн хэрэглээг нэмэгдүүлнэ.</td>
<td>-</td>
<td>Эмч, эмнэлгийн ажилчдын Uptodate олон улсын эмнэлзүйн удирдамжийн хэрэглээний хувь /CME/</td>
<td>Эмч, эмнэлгийн ажилчдын Uptodate олон улсын эмнэлзүйн удирдамжийн хэрэглээ нэмэгдэж CME 100 болсон байна.</td>
<td>Жилийн турш</td>
<td>2021 онд 23 эмч 2876 CME буюу дунджаар 169,1 байсан бол 2022 онд 24 эмч хэрэглэж 4600 CME болж өссөн байна. Хамгийн өндөр оноотой эмч Г.Цогзол 636.0 байна.
<table>
<tr><th>№</th><th>Эмч нарын нэрс</th><th>CME 2022/07</th><th>CME 2022/12</th></tr>
<tr><td>1</td><td>Урангоо</td><td>407.5</td><td>486,5</td></tr>
<tr><td>2</td><td>Цогзол</td><td>545</td><td>636,0</td></tr>
<tr><td>3</td><td>С.Солонго</td><td>296</td><td>411,0</td></tr>
<tr><td>4</td><td>Г.Баянжаргал</td><td>182</td><td>214,0</td></tr>
<tr><td>5</td><td>Д.Мөнгөнтүлхүүр</td><td>153</td><td>227,0</td></tr>
<tr><td>6</td><td>Д.Сүхболд</td><td>165</td><td>221,0</td></tr>
<tr><td>7</td><td>Б.Баярмаа</td><td>42,5</td><td>65,0</td></tr>
<tr><td>8</td><td>С.Билгүүнцоож</td><td>165</td><td>206,5</td></tr>
<tr><td>9</td><td>Мөнхзаяа</td><td>135</td><td>137,0</td></tr>
<tr><td>10</td><td>Б.Амаржаргал</td><td>75</td><td>83,0</td></tr>
<tr><td>11</td><td>Ганбаяр</td><td>97.5</td><td>163,0</td></tr>
<tr><td>12</td><td>Н.Золбаяр</td><td>145.5</td><td>201,0</td></tr>
<tr><td>13</td><td>У.Саруул</td><td>130</td><td>225,5</td></tr>
<tr><td>14</td><td>Чанцалдулам</td><td>60</td><td>90,0</td></tr>
<tr><td>15</td><td>Энхсайхан</td><td>174</td><td>233,0</td></tr>
<tr><td>16</td><td>Ж.Аззаяа</td><td>-</td><td>82,0</td></tr>
<tr><td>17</td><td>Ж.Энхжаргал</td><td>-</td><td>59,0</td></tr>
<tr><td>18</td><td>Б.Лхагвасүрэн</td><td>-</td><td>266,5</td></tr>
<tr><td>19</td><td>А.Хулан</td><td>-</td><td>35,5</td></tr>
<tr><td>20</td><td>Ч.Намуунтуяа</td><td></td><td>339,5</td></tr>
<tr><td>21</td><td>Ч.Эрдэнэчимэг</td><td>-</td><td>71,5</td></tr>
</table>
</td>
<td>100</td>
</tr>
</table>

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td><table><tr><td>22</td><td>Энхжин</td><td>22,5</td><td>70,5</td></tr><tr><td>23</td><td>Б.Батцэцэг</td><td></td><td>61,5</td></tr><tr><td>24</td><td>Т.Булганцэцэг</td><td>-</td><td>14,5</td></tr><tr><td>25</td><td>Ёндондаш</td><td>80.5</td><td>-</td></tr></table></td><td></td></tr>
<tr><td>14.</td><td>3.1.3</td><td>МУУХХБ-2.2.21, ЗГҮАХ-2.1.3. ISO 9001:2015 олон улсын чанарын менежментийн тогтолцоог магадлах аудитаар баталгаажуулна.</td><td>0.5 /өөрийн орлого/</td><td>Аудитын үнэлгээ</td><td>ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцооны стандартын шаардлагыг хангаж ажилласан байна.</td><td>2 улирал</td><td>Стандарт хэмжил зүйн газрын чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015/MNS ISO 9001-2016 стандартын магадлах аудитаар 2022 оны 06 сарын 02-03-ны өдрүүдэд шалгуулж үл тохиролгүй гэж дүгнэгдсэн.<br><br><br>Чанарын удирдлагын тогтолцооны стандартыг хэрэгжүүлэх зорилгоор дотоодын нийт 106 журам, 26 заавар, 21 арга аргачлал, 34 удирдамж дотооддоо баталж мөрдөж ажиллаж байна.</td><td>100</td></tr>
<tr><td>15.</td><td>3.1.4</td><td>ЗГҮАХ-2.1.3. Нийт эмнэлгийн ажилчдад чанарын сургалтыг тогтмол зохион байгуулна.</td><td>-</td><td>Сургалтад хамрагдсан ажилчдын хувь</td><td>10 чиглэлээр чанарын сургалтыг зохион байгуулж, нийт ажилчдын 90-ээс доошгүй хувь хамрагдсан байна.</td><td>Жилийн турш</td><td>АӨСҮТ-өөс "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах" жилийн хүрээнд нийт эмнэлгийн 247 ажилчдад 4 чиглэлийн сургалт зохион байгуулсан. Үүнд:<br>1. 2022 оны 06 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд "Эрүүл мэндийн чанарын холбоо" ТББ-тай хамтран “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал” сэдэвт чанарын сургалтыг тус төвийн чанарын багийн гишүүн 23 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдад зохион байгууллаа. Тус сургалтыг ЭМЧХ-ны үндэсний сургагч багш М.Оюунчимэг, Ж.Нармандах, Э.Тунгалаг, Т.Дулмаа нар</td><td>100</td></tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | удирдан дараах сэдвүүдээр чанарын тухай мэдлэгийг дээшлүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдол, эрсдэлийг бүртгэж, мэдээлэх, хариу арга хэмжээний талаар ойлголтыг өгсөн:<br>- Чанарын тухай үндсэн ойлголт, үзэл баримтлал, зарчмууд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар сайжруулах арга хэрэгслүүдийн тухай<br>- Эрүүл мэндийн байгууллагын чанарын хяналт, үнэлгээ, дотоод хяналтыг хэрхэн зохион байгуулах<br>- Эрүүл мэндийн байгууллагын чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө боловсруулах, үнэлэх, тайлагнах арга<br>- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрсдэлийн үнэлгээ хийх арга зүй<br>- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах<br>- Эрүүл мэндийн салбарын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх<br>- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах<br> | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2. 2022 оны 01 сарын 04, 06 -ны өдөр “Ойрын болон хэтийн төлөвлөгөөнд өгөх санал авах, ажлын гүйцэтгэлийг тодорхойлж, үнэлгээг боловсруулах” сэдэвт COPE ярилцлагыг хийж эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сувилагч, тусгай мэргэжилтэн, удирдлага, албадын дарга нар оролцсон. COPE ярилцлагын саналыг байгууллагын стратеги төлөвлөгөө, 2022 оны байгууллагын төлөвлөгөө, албадын төлөвлөгөөнд тус бүр тусгасан. Нийт 88 ажилтан хамрагдсан.<br><br>3. Дэмжих үйлчилгээний ажилчдад 2022 оны 03 сарын 24-нд “Дэмжих үйлчилгээний ажилчдын ажлын гүйцэтгэл, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, үнэлгээний аргыг боловсруулах” санал авах “COPE” ярилцлагыг амжилттай зохион байгуулж, ажилчдын саналыг гүйцэтгэлийг сайжруулах шалгуур үзүүлэлтэд тусгасан.<br>4. ЭЭЯТТасгийн их эмч У.Саруул, статистикч их эмч Б.Оюунтуяа нар Real time нэхэмжлэлтэй холбоотой эрчимт эмчилгээнд өвчний түүх нээх, яаралтай тусламжаар үйлчлүүлэгчдийг хэрхэн бүртгэх талаар сургалт зохион байгуулав.<br>5. Жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны өдөр тохиох “Дэлхийн чанарын өдөр”-ийг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тохиолдуулан “Тусламж, үйлчилгээний чанарын асуудалд” сэдэвт цахим хуралд ЭМТҮЧАБА-ны дарга Б.Баярмаа, ЭМТҮЧАБА-ны менежер Ж.Булган нар хамрагдсан.<br>6. MNS ISO 19011: 2020 “Менежментийн тогтолцоонд аудит явуулах заавар” сэдэвт сургалтад клиникийн 1-р тасгийн ахлах сувилагч Б.Жавхлант, ЭМТҮЧАБА-ны эрсдэлийн менежер Ж.Булган нар 2022.11.09-2022.11.10-ны хооронд хамрагдсан.<br>7. ЭМДЕГ-аас зохион байгуулсан ЭМДҮЗ-ийн 01 тогтоол болон бодит цагийн нэхэмжлэлтэй холбоотой онлайн сургалтад ҮАЭДЗ Т.Баярмаа, ЭМТҮЧАБАД Б.Баярмаа, статистикч эмч Б.Оюунтуяа, даатгал хариуцсан ажилтан Н.Билгүүн нар хамрагдсан<br> | |
| 16. | 3.1.5 | ЗГҮАХ-2.1.3. Иммунологи, гистологи, бусад өвөрмөц шинжилгээгээр онош баталгаажуулна. | 30 /өөрийн орлого/ | Оношийн зөрүү гарсан шинжилгээний тоо | .<br>Нийт 500 өвөрмөц шинжилгээг хийж оношийг баталгаажуулна. Клиник оношийн зөрүүгүй ажилласан байна. | Жилийн турш | 2022 онд арьсны эдийн шинжилгээ 598, шууд дархан туяарах шинжилгээ 8, эсийн шинжилгээ (цитологи) 33 тус тус хийгдсэн байна.<br>Нийт арьсны эдийн шинжилгээг дүгнэвэл нийт өвөрмөц тохиолдлууд 301 (50.4%), бусад өвчин эмгэгүүд 297 (49.6%) байна.<br>- арьс дайврын хортой хавдар - 31 (10.3%)<br>- арьс дайвар, зөөлөн эдийн хоргүй хавдар - 78 (25.9%) | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - хавдрын урьдал өвчнүүд - 25 (8.3%)<br>- бусад өвөрмөц өвчнүүд - 167 (55.5%)<br>Арьсны хортой болон бусад өвөрмөц өвчнүүд өмнөх жилүүдээс их оношлогдож байна. Нас баралтын 1 тохиолдол тайлант хугацаанд бүртгэгдсэн бөгөөд эмгэг судлалын задлан шинжилгээнд орж оношийн зөрүү илрээгүй болно. Үндсэн онош: лайеллийн хам шинж, олон эмэнд тэсвэртэй нянгаар үүсгэгдсэн үжил. | |
| 17. | 3.1.6 | МУУХХБ-2.2.21, ЗГҮАХ-2.1.3. Лабораторийн шинжилгээний гадаад, дотоод хяналтын тасралтгүй байдлыг хангана. | 30 /өөрийн орлого/ | Гадаад, дотоод хяналтын үнэлгээний тайлан | Лабораторийн шинжилгээний гадаад /2/ , дотоод хяналтын /250/ үнэлгээний тайлан гарсан байна. | Жилийн турш | ➢ Гадаад чанарын хяналт:<br>- Гематологи болон биохимийн шинжилгээний гадаад хяналтын дүн 2022 оны 2-р сард ирсэн. Биохимийн гадаад хяналтад 62.96%тай. Гематологийн гадаад хяналтад 90.00%, үнэлэгдсэн.<br> <br>- 2022 оны 08-р сарын 16ны өдөр болсон гематологи биохимийн чанарын гадаад үнэлгээнд амжилттай оролцож гематологи 95% биохими 80,74% үнэлэгдсэн байна<br>- 2022 оны 06 сарын 23 ны өдрийн 17 дахь удаагын гадаад хяналтанд амжилттай оролцсон .<br>- Цусны бүлэг тодорхойлох шинжилгээнд 100%, хувийн тохироо тодорхойлох шинжилгээнд 100% үнэлгээтэй оролцсон.<br>➢ Дотоод чанарын хяналт: | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Биохими, гематологи шинжилгээнд дотоод хяналтыг өдөр бүр уншуулж жилд 264 удаа хяналт хийсэн байх<br>- ШЕШ шинжилгээнд сард 1 удаа дотоод хяналт уншуулж байна.<br>- Иммунологийн шинжилгээг шинэ урвалж задлах бүртээ хяналтуудыг хийж хэвшиж байна.<br>- Шинээр Нян судлал дээр эмгэг төрөгч 3 төрлийн омог Stapylocoocus aureus стандарт омог, E.coli стандарт омог ,Aerococcus viridans стандарт омогуудаар дотоод хяналтуудаа хийж байна.<br> | |
| 18. | 3.1.7 | ЗГҮАХ-2.1.3, 2.1.18. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ, чанар аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж ажиллана. | - | Хийсэн хяналтын тоо, Илрүүлсэн зөрчил Авсан арга хэмжээний тоо | Нийт 10 чиглэлээр 20 удаагийн хяналт хийж, илрүүлсэн зөрчилд арга хэмжээ авч ажилласан байна. | Жилийн турш | Эмнэлгийн тусламж, үйлчилгээ, чанар аюулгүй байдалд 9 чиглэлээр 39 удаагийн хяналт хийж, арга хэмжээг авч ажилласан. Үүнд:<br>1. 2022 онд нийт эмчилгээ, үйлчилгээтэй холбоотой 20 тохиолдол тасаг, албадад бүртгэгдсэн ба хариу арга хэмжээ авч ажиллаж байна. Бүртгэгдсэн нийт тохиолдлыг үнэлэхэд 1А ангилал-11, 1Б ангилал -4, 2 ангилал-5, шалтгаанаар авч үзвэл бусад шалтгаантай-13, харилцааны дутагдал, доголдол- 1, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний халдвар-6, нөлөөх хүчин зүйлийн хувьд ажилтны хүчин зүйл -9, баримт бичиг технологийн хүчин зүйл-5, үйлчлүүлэгчийн хүчин зүйл-1, багийн хүчин зүйл-2, хавсарсан хүчин зүйлс-2 байлаа. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2. ЭМС-ын 2019 оны А/565 тоот тушаалын дагуу эмч нар улирал бүр өвчний түүх, амбулаторийн картад хуваарийн дагуу оношилгоо, эмчилгээний стандартын мөрдөлтийг ижил мэргэжилтний үзлээр хяналт хийдэг. 1-р улирлын 201 ижил мэргэжилтний үнэлгээний маягтад дүн шинжилгээ хийсэн ба, 123 (61,2%) амбулаториор эмчлүүлэгчийн картын үнэлгээ (10 эмч хамрагдсан), 78 (38,8%) өвчний түүхэнд хийсэн үнэлгээ (4 эмч хамрагдсан ) хамруулсан. Арьсны хэсэг газрын (өвөрмөц) үзлэгийг бүрэн бус хөтөлсөн 22%, огт хөтлөөгүй 4,9% байв. Ижил мэргэжилтний үнэлгээ хийсэн эмчийн үнэлгээгээр, үнэлүүлсэн эмчийн ерөнхий үнэлгээ нь амбулаторийн карт хөтлөлтөд 10,6-39,4% хангалтгүй байв. Эдгээр үзүүлэлтийг сайжруулахын тулд практик зөвлөмж боловсруулан, эмч нарт танилцуулсан. Ижил мэргэжилтний үнэлгээг эмч нарт 4, сувилагч нарт 4, үйлчлүүлэгч нарт 2 төрлийн үнэлгээний маягт ашиглан хийж байна.<br>3. Байгууллагын эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг 10 зорилт бүхий 26 эрсдэлийг тодорхойлон батлуулж эрсдэлээс урьдчилан сэргийлэн хариу арга хэмжээ авч ажиллаж байна. АӨСҮТ-ийн эрсэхийн санг үүсгэн ЭМС-ын 2019 оны 12 сарын 12-ын өдрийн А/566 тоот тушаал, АӨСҮТөвийн захирлын 2020 оны 05 сарын 05-ний өдрийн А/14а тушаалын дагуу үнэлэн, хариу арга хэмжээ авч ажилласан. Эрсдэлийн дундаж оны эхэнд 12 байсныг жилийн эцэст 10 болгож бууруулсан.<br>4. АӨСҮТөвд эрчимт эмчилгээний тасаг, энгийн тасаг, ковидын тасагт хэвтэн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эмчлүүлсэн өвчний түүхэнд оношилгоо, эмчилгээний стандартын дагуу чанарын хяналт хийсэн. Тасгийн эрхлэгч, ахлах сувилагч нар тасаг нэгжид хөтлөгдөх анхан шатны маягтад хяналт хийн сайжруулан ажилладаг.<br>5. Өвчтөний өрөөнд өдөр тутам хийгдэх цэвэрлээг үнэлэх хуудсаар тасаг бүрд үнэлгээ хийж, гарсан зөрчлийг арилгуулсан. Гэрлийн унтраалга, тоног төхөөрөмжийн хөл, суултуур бохир, цонх халтар, шал толботой зэрэг зөрчил илэрсэн. 12 асрагч нараас эрүүл мэндийн байгууллагын цэвэрлэгээ, үйлчилгээ, гар угаалт сэдвээр сургалтын өмнө болон дараа гэсэн 2 удаа тест авсан. Эрүүл мэндийн цэвэрлэгээ үйлчилгээ сэдвээр сургалт зохион байгуулж зөрчлийг арилгаж хяналтын хуудсаар дахин хяналт тавьж ажиллалаа.<br>6. Эмнэлгийн цагаан хэрэгсэл нь гэрээний дагуу хийж гүйцэтгэдэг ба ирсэн цагаан хэрэглэлд хяналт тавьж ажиллахад алдаа зөрчил гараагүй, нян судлалын шинжилгээгээр нян илрээгүй байна.<br>7. Тасгийн эмч, сувилагч,асрагч нараас гар угаах, халдваргүйжүүлэх дадлыг нийт 10 /давхардсан тоогоор/ ажилчдыг хяналтын хуудсаар дүгнэхэд дараалал алдагдсан, гар угаах хугацаа богино, гарын эрүүл ахуй сахих 5 заалтыг буруу хэлсэн зэрэг зөрчил гарсны дагуу эмс-ын а/537 тоот тушаалын дагуу эмч, эмнэлгийн ажилчдад “Гар угаах, халдваргүйжүүлэх” сургалт зохион байгуулж арга хэмжээ авч ажиллалаа<br>8. Өртөлтийн дараах цомгийн бэлэн байдлыг шалгуур хуудсаар шалгахад тасаг нэгжийн өртөлтийн цомог бүрэн ба хугацаа нь | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дууссан эм, эмнэлгийн хэрэгсэл байхгүй, зөрчилгүй байсан. 2022 оны 6 дугаар сар 22-нд “Өртөлт ба өртөлтийн дараах сэргийлэлт” сэдвээр 25 ажилтанд сургалт зохион байгуулж, ЭМС-ын А/537 тоот тушаалын дагуу тест бэлдэж сургалтын өмнө болон дараах тестийг авсан. Тасаг нэгжийн ажилчдаас өртөлтийг үнэлэхэд 87.6%-тай үнэлэгдсэн байна. 9 тасаг нэгжээс 3 тасаг нэгжийн өртөлтийн дараах цомгийн бэлэн байдал хангагдсан байна. Илэрсэн 6 зөрчлийг арилгах талаар зөвлөмж өгч ажилласан. Мөн шинээр орсон 10 ажилтанд болон резидент эмч нарт өртөлт, өртөлтийн дараах сэргийлэлт сэдвээр 2 удаа сургалт зохион байгуулсан. | |
| 19. | 3.1.8 | ЗГҮАХ-2.1.3. Тохиолдолд суурилсан эмнэлзүйн конференцыг зохион байгуулна. | 0.1 /өөрийн орлого/ | Эмнэлзүйн хэлэлцүүлгийн тоо | Тохиолдолд суурилсан эмнэлзүйн хэлэлцүүлгийг тохиолдол бүрд зохион байгуулсан байна. | Жилийн турш | Эмнэлзүйн конференцийг нас барсан тохиолдол болон ор хоног 1 сараас дээш үйлчлүүлэгч нарт хийх бодлого баримталдаг.<br>1. 2022 оны 4 сард Лайеллийн хам шинж, Арьсны дутагдал, Үжил оношоор нас барсан тохиолдолд ЭСҮТөвтэй хамтран зохион байгуулсан. Оношийн зөрүү гараагүй.<br>2-3. Жинхэнэ цэврүүтэх өвчин оноштой ор хоног 33 өвчтөнд уламжлалт глюкокортокостеройд даавар эмчилгээ болон ор хоног 46 хоногтой өвчтөнд бай эмчилгээг шинээр хийсэн тохиолдлуудад эмнэлзүйн үр дүнг үнэлэхээр эмнэл зүйн хэлэлцүүлэг хийсэн.<br>4. Тус төвийн яаралтай тусламжийн тасгаар, амбулаторийн тасгаар, ХСҮТөвийн яаралтай тусламж, ГССҮТөвийн яаралтай тусламж, СХД-ийн яаралтай тусламжаар үйлчлүүлж, олон | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эмнэлгээр онош тодрохгүй явсаар ХСҮТөвийн яаралтай тусламжийн хэсэгт нас барсан тохиолдолд эмнэлэг хамтарсан эмнэл зүйл конференциуд 12-р сард багтаан хийгдэхээр хүлээгдэж байна.<br>Зөвлөх эмчийн эмч нарын нийт 97 хамтарсан үзлэгийг тайлангийн хугацаанд хийж эмчилгээ, үйлчилгээний асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэж ажилласан.<br>Мөн төвийн нийт эмч нарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр эмгэг анатомын профессор Э.Баярмаа "Оношийн тухай ойлголт" сэдвээр цахим сургалт зохион байгуулав. Нийт 18 эмч, резидент эмч нар хамрагдсан.<br><br> | |
| 20. | 3.1.9 | ЗГҮАХ-2.1.10. Үйлчлүүлэгчийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэнэ. | - | Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо | Үйлчлүүлэгчийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг 100 хувь шийдвэрлэсэн байна. | Жилийн турш | Иргэний өргөдөл, гомдлыг аман, биечлэн, утсаар, цахимаар, 11-11, бичгээр, санал хүсэлтийн дэвтрээр хүлээн авч бүртгэн, хариу арга хэмжээ авч шийдвэрлэн ажилладаг. Улирал бүр иргэний өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн тайланг ЭМХТ хүргүүлдэг. 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт санал 18, хүсэлт-9, өргөдөл, гомдол-23 хүлээн авч, өргөдөл, гомдлыг 100% шийдвэрлэн ажилласан. | 100 |
| 21. | 3.1.10 | ЗГҮАХ-2.1.3, 2.1.18. Дотоод хяналтын нэгжийн | 0.2 /өөрийн орлого/ | Төлөвлөсөн арга хэмжээни | Дотоод хяналтын нэгжийн | Жилийн турш | 2022 онд нийт 7 чиглэлээр хяналт шалгалт зохион байгуулсан. Үүнд:<br>1. 2021 оны байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний нийт 17 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тасралтгүй байдлыг хангаж ажиллана. | | й хэрэгжилтийн хувь | төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь биелсэн байна. | | зорилтын хүрээнд 88 арга хэрэгжилтийн байдалд хяналт хийхэд хэрэгжилт 98.3 хувьтай үнэлэгдсэн.<br>2. Яаралтай тусламж, хүлээн авахаар ирсэн үйлчлүүлэгчдэд эмч, эмнэлгийн ажилчдын үзүүлж буй тусламж үйлчилгээ, бүртгэл, эрэмбэлэлтийн байдалд хяналт хийж 3 зөрчлийг илрүүлж арга хэмжээг авч ажилласан.<br>3. Нийт 86 төрлийн тоног төхөөрөмжийн бүртгэл, засвар үйлчилгээний байдалд хяналт үнэлгээг хийсэн. Гэрээт тоног төхөөрөмжийн инженер техник ашиглалтын паспортыг бүрэн хөтөлж, техник үйлчилгээ, засварыг цаг хугацаанд хийж байна. Зүрхний цахилгаан бичлэгийн тохируулга алдагдсан байсныг илрүүлж тохируулгыг хийв. Өдрийн эмчилгээний кабинет, лабораторийн асгийн центрифуг ажиллахгүй,эвдэрсэн байсан тул шинээр захиалж суурилуулсан.<br>4. Эмч, эмнэлгийн нийт 155 ажилчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтэд 9 чиглэлээр хяналт шинжилгээг хийж үнэлсэн. Цаашид нийгэм хамгаалал болон сурч хөгжих боломжийг бүрдүүлж, гэрээний дагуу хүлээх эрх, үүрэг, хариуцлагын хэрэгжилт дээр анхаарч ажиллахаар төлөвлөөд байна.<br>5. 2022 оны байгууллагын хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт шинжилгээ үнэлгээг хийсэн. Хэрэгжилт 95 хувь байна.<br>6. Байгууллагын дотоод журмын хэрэгжилтэд хяналт хийхэд Хөдөлмөрийн шинэчилсэн хуулийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дагуу өөрчлөх шаардлагатай 15 заалт байсныг илрүүлж, журмыг шинэчлэх шаардлагатай байгаа талаар удирдлагын зөвлөлд танилцуулав.<br>7. 2022 оны 12 сард байгууллагын жилийн төлөвлөгөө, тайланд хяналт шинжилгээ үнэлгээг хийхээр төлөвлөж байна. | |
| 22. | 3.1.1 1 | МУУХХБ-2.2.21, ЗГҮАХ-2.1.3. Хөндлөнгийн байгууллагын хяналт, шалгалтын дагуу өгсөн албан шаардлагыг биелүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | 5 /өөрийн орлого/ | Албан шаардлагын хэрэгжилтийн хувь | Хөндлөнгийн байгууллагын хяналт, шалгалт, албан шаардлагыг 100 хувь хангаж ажилласан байна. | Жилийн турш | ➢ ЭМДЕГ-аас нийт тусламж үйлчилгээ тус бүрийн 15%-ийг түүврийн аргаар байцаагч болон эмчийн чанарын хяналт хийн санхүүжилт олгодог. Даатгалын чанарын хяналтаар нийт 150 өвчтөний түүхэнд зөрчил илэрч 92,110,449 төгрөг хасагдсан бөгөөд ЭМД-аас өгсөн зөвлөмжийг тухай бүр хэрэгжүүлэн, алдаа дутагдал, зөрчлийг арилгаж ажиллаж байна.<br>➢ Эрүүл мэндийн салбарын чанар, аюулгүй байдлын жил" болгон зарласантай холбоотойгоор ЭМЯ-ны ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэйгээр тусламж үйлчилгээний явцын хяналтыг дараах чиглэлээр хийн, дэмжин туслах зөвлөгөө өгч ажилласан.<br>1.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал<br>2.Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал<br>3.Халдварын сэргийлэлт, хяналт шалгалтын үеэр өгсөн нийт 8 зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллалаа.<br>➢ 2022 оны 01 сард ЭМДЕГ-ын даатгалын гэрээ дүгнэх үнэлгээний хуудасны дагуу үнэлгээнд хамрагдсан.<br>➢ СБД-ийн МХГ-аас хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой 20 чиглэлээр | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хяналт шалгалт хийхэд 8 зөрчил илэрсэн. Хяналт шалгалтаар илэрсэн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан. | |
| *Зорилт 3.2. Эмнэлгийн халдвар, хамгаалал, аюулгүй байдлыг хангах* | | | | | | | | |
| 23. | 3.2.1 | ЗГҮАХ-1.1.3.1. Коронавируст (Ковид-19)-ын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана. | 50 /өөрийн орлого/ | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Коронавируст (Ковид-19)-ын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. | Жилийн турш | 2022 оны 1 дүгээр сарын 17-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 09-ны өдөр хүртэлх хугацаанд коронавирус халдвартай иргэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нийт 40 орыг дэлгэсэн. Тусламж үйлчилгээг нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй эмч, эмнэлгийн ажилчид хуваарь гарган ээлжээр ажилласан.<br>➢ Коронавируст халдварын батлагдсан тохиолдлыг тусгаарлан эмчлэх хэсгийг халдвартай буюу улаан, халдварын эрсдэл дунд буюу шар, халдваргүй буюу ногоон гэсэн 3 бүсэд хувааж, тусгаарлалтыг зохион байгуулсан.<br>➢ Хамгаалах хувцас хэрэгслийг зөв өмсөх, аюулгүй тайлах, гарын эрүүл ахуй сахих, халдваргүйжүүлэх бодисыг зөв хэрэглэх, хог хаягдлын менежмент, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх зэрэг халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлийг баримтлан ажилласан.<br>➢ Эмч эмнэлгийн ажилчид батлагдсан тохиолдолтой хавьтал болох эрсдэл өндөр байгаа тул тогтмол тандалт судалгааг хийсэн.<br>➢ Ажилчид болон хэвтэн эмчлүүлэгчийг 7 хоногт 3 удаа ПГУ/PCR/-ийн шинжилгээнд хамруулж байсан. Нийт 1129 ПГУ /PCR/ шинжилгээ авсан. Үүнээс:<br>- Хэвтэн эмчлүүлэгч- 701 Батлагдсан тохиолдол-4 /хүүхэд-1, 1,2-р тасаг-2, эрчимт-1/ | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Ажилчид-331 /давхардсан тоогоор/ Батлагдсан тохиолдол-43/<br>- Сайн дураараа-95<br>➢ ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу /амны хаалтыг 2 цаг тутамд солих/ эмнэлгийн ажилчдад өдөрт 4 ширхэг маск тараасан.<br>➢ Халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор жавелионы 0.06%-ийн процентоор найруулан эмнэлгийн халдваргүйтгэлийг өдөр бүр хийж байна. Үйлчлүүлэгчийн бөөгнөрөл ихтэй лаборатори, амбулатори, ЭЭЯТТ-т 2 цаг тутам агаарын мананцар үүсгэгчээр халдваргүйжүүлэлт хийсэн.<br>➢ Коронавирусын халдвараас сэргийлэх зорилгоор гар угаах, халдваргүйжүүлэх уусмалаар хангаж ажиллаж байна. Тусламж үйлчилгээ үзүүлж байгаа цэг бүрд гар халдваргүйжүүлэх уусмал хүрэлцээгүй 70 хувийн спиртийн агууламж гар халдваргүйжүүлэх бодисоор ханган ажилласан.<br>➢ Коронавирус халдварын мэдээ мэдээллүүдийг эмнэлгийн дотоод хуудсанд байршуулж мэдээллээр хангаж ажилласан.<br>➢ 2022 оны байдлаар хэвтэн эмчлүүлэгчдэд нийт 1609 коронавирусыг халдварыг илрүүлэх түргэвчилсэн тестийн шинжилгээг хийсэн.<br>➢ Коронавируст халдвартай өвчтөнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх болон болон үндсэн үйл ажиллагааны бэлэн байдлыг хангаж ажиллах зорилгоор эм, эмнэлгийн хэрэгслийн 2 сарын нөөцийг бэлэн байлгаж, мэдээг сар бүр ЭМЯ-ны burtgel.mn өгч байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 24. | 3.2.2 | МУТЖҮЧ-9.2.2. Эмнэлгийн болон ахуйн зориулалтын хог хаягдлын менежментийг төлөвлөн хэрэгжүүлнэ. | 18 /өөрийн орлого/ | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Эмнэлгийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлсэн байна. | Жилийн турш | ➢ Хог хаягдлын ажилтан эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлж аюултай хог хаягдалтай харьцах, аюулгүй болгох заавар, зөвлөмжийн хэрэгжилтэд улирал бүр хяналт тавьж, зөвлөгөө өгч байна.<br>➢ ЭМС-ын А/505 тоот тушаалаар эмнэлгийн ажилчдад “эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал” сэдвээр 36 /давхардсан тоогоор/ ажилтанд 2 удаа, “эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент” сургалтыг 25 ажилтанд зохион байгуулсан. Сургалтын үеэр ажилчдыг баг болгож хог хаягдлыг ангилуулсан.<br><br>➢ ЭМЯ болон ХӨСҮТ-ийн хамтарсан “эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент” сэдэвт 2 өдрийн сургалтад халдвар судлаач хамрагдсан.<br><br>➢ Хог хаягдлын бүртгэлийг тасаг бүрээр хөтлөн, сар бүр эмнэлгийн гаралтай хог хаягдлын тоо хэмжээг нэгтгэн гаргаж, | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ХӨСҮТ болон холбогдох байгууллагуудад мэдээлдэг. Мөн ЭМС-н 2017оны 12 сарын 12-ны өдрийн А/505 тоот тушаалын дагуу эрүүл мэндийн аюултай хог хаягдлыг бүртгэх, тээвэрлэх устгах тухай бүртгэлийн маягтуудыг үйл ажиллагаандаа ашиглаж байна. 4 төрлийн 60 ширхэг гарын авлагыг тасаг нэгжийн ажилчдад тараасан.<br><br><br>➢ ЭМС-ын а/505 тоот тушаалын дагуу эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг энгийн болон аюултай хог хаягдлаар ангилан ялгалт хийж, тэмдэг тэмдэглэгээг байршуулж зөв ангилан ялгаж байна. 20 ширхэг тэмдэг тэмдэглэгээг тасаг нэгжүүдэд байршуулсан.<br>1. “Элемент”ХХК-тай эм, эмийн гаралтай химийн бүтээгдэхүүн болон эмнэлгийн туслах материал тээвэрлэх, устгах гэрээ байгуулсан.<br>2022 оны жилийн эцсийн байдлаар<br>- ХХХ-ын нийт хэмжээ 3318кг 190 гр,<br>- Эмнэлгийн халдвартай хог хаягдал нийт 2395кг 112 гр<br>- Хурц үзүүртэй хог хаягдал нийт-923кг 628 гр<br>Гэрээний дагуу “Элемент” ХХК-д хүлээлгэн өгч устгал хийлгэсэн. Хог хаягдлын савыг заавper дагуу угааж цэвэрлэдэг. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |  | |
| 25. | 3.2.3 | МУТЖҮЧ-2.5.4. Ажлын байрны орчны эрсдэлийн үнэлгээг хийнэ. | 0.1 /өөрийн орлого/ | Орчны эрсдэлийн үнэлгээ | Ажлын байрны орчны эрсдэлийн үнэлгээг 7 чиглэлээр хийсэн байна. | Жилийн турш | Байгууллагын эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг 10 зорилт бүхий 26 эрсдэлийг тодорхойлон батлуулж эрсдэлээс урьдчилан сэргийлэн хариу арга хэмжээ авч ажиллаж байна. АӨСҮТ-ийн эрсдэлийн санг үүсгэн ЭМС-ын 2019 оны 12 сарын 12-ын өдрийн А/566 тоот тушаал, АӨСҮТөвийн захирлын 2020 оны 05 сарын 05-ний өдрийн А/14а тушаалын дагуу үнэлэн, хариу арга хэмжээ авч ажилласан.<br>2022оны байдлаар ажлын байрны орчны эрсдэлийн үнэлгээг хийж дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ:<br>1. Байгууллагын гаднах талбайн машины зогсоолуудыг засварлаж тохижуулсан.<br>2. Үйлчлүүлэгч тав тухтай орчинд үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлж хүлээлгийн танхимуудын гэрэлтүүлгийг бүрэн шийдэж, амбулаторийн үйлчлүүлэгчийн суух сандлуудыг бүрдүүлж өгсөн.<br>3. Ариун цэврийн өрөөнүүдэд төмөр хаалт, бариул хийсэн.<br>4. А корпусын 4 давхрын шатны их засварыг хийж ажлын байрны орчны аюулгүй байдлыг хангасан.<br>Эрсдэлийн дундаж 2022 оны эхэнд 12 байсан жилийн эцэст 10 болгож бууруулсан | 100 |
| 26. | 3.2.4 | МУТЖҮЧ-2.2.1. Угаалгын байрны | 20 /улсын төсөв/ | Угаалгын байрны барилгын | Угаалгын байрны барилгын | | Угаалгын байрны барилгын зураг, төсвийг батлуулсан. Хэмнэлтийн хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | барилгын ажлыг эхлүүлнэ. | | ажлын явцын хувь | ажлын гүйцэтгэл 20 хувьд хүрсэн байна. | 3,4 дүгээр улирал | төсөл, арга хэмжээний жагсаалтад барилгын ажлын засвар, шинэчлэлийг ажлыг хориглосон тул түр хугацаагаар хойшлогдоод байна. | |
| | ЗОРИЛГО 4. ТАСРАЛТГҮЙ СУРАЛЦАГЧ БАЙГУУЛЛАГА БАЙЖ, ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ | | | | | | | |
| *Зорилт 4.1. Арьс харшил, эмчилгээний гоо заслын чиглэлээр чадварлаг хүний нөөцөөр хангаж, мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх* | | | | | | | | |
| 27. | 4.1.1 | МУТЖҮЧ-2.2.8, ЗГҮАХ-2.1.9. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө, боловсруулан хэрэгжүүлнэ. | - | Батлагдсан хөтөлбөр, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт 25 хувь байна. | Жилийн турш | 2022-2026 оны байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн 5 зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:<br>I. Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны MNS6330:2017 стандартаар эмч, сувилагчийн харьцаа 1:1.5 хүргэхээр төлөвлөн ажиллаж байна. 2022 онд поликлиникийн тасагт 1, ЭЭЯТ тасагт гэрээт-1, хүүхэд асрах чөлөөнөөс-1 нийт 2 сувилагч, 1-р тасагт 1, хүүхдийн тасагт 1 гэрээт сувилагч нийт 5 сувилагчийн сонгон шалгаруулж шинээр ажилд авсан<br>II. Дотоодын 30 чиглэлийн сургалт болон гадаадын 48 чиглэлийн сургалтад давхардсан тоогоор нийт 750 гаруй ажилчид хамрагдаж, өндөр хөгжилтэй гадаадын орнуудад нийт 4 эмч амжилттай суралцаж байна.<br>Дараах сургалтуудын дотооддоо зохион байгууллаа. Үүнд:<br>1. 2022.01.18-ны өдөр Сургалтын албанаас “Оношийн хэлбэржилт, нас баралт, түүнийг бүртгэх, мэдээлэх нь” сэдэвт сургалт зохион байгуулж 50 /эмч -24, резидент-26/ хамрагдлаа.<br>2. 2022.02.18-нд АШУҮИС-ийн НЭМХ-ийн Эрүүл мэндийн бодлого, менежментийн судалгааны төвтэй хамтарч “Байгууллагын стратеги төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлага” сэдэвт | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтыг АӨСҮТ-ийн хурлын танхимд зохион байгуулсан. Сургалтад удирдлагын баг, тасаг нэгжийн удирдлагууд бүхий 30 эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан.<br>3. 2022.03.03-ны өдөр “Коагулограмын аппарат ашиглах заавар” Лабораторийн их эмч А.Дулмаа тасгийн нийт ажилчдад ажлын байрны сургалт зохион байгуулсан.<br>4. 2022.03.04-ны өдөр Сэтгэл судлалын магистр, эмч Б.Ариунцацралтай хамтарч “Сэтгэцийн эрүүл мэнд ба стресс тайлах менежмент” сэдэвт сургалтыг төвийн хурлын танхимд зохион байгуулсан. Сургалтад 34 эмч болон эм зүйчид, 20 сувилагч, 2 аж ахуйн албаны ажилчид хамрагдсан.<br>5. 2022.03.24-ний өдөр Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам хэрэгжилтийг хангах хүрээнд АӨСҮТ-ийн ажилчид орон даяар гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилтад төвийн нийт 154 эмч, эмнэлгийн ажилчид хамрагдсан.<br>6. 2022.03.25-ны өдөр үйлчлүүлэгчийн аюулгүй байдал сэдэвт сургалтыг лаборант Б.Мөнхнасан лабораторийн тасгийн хамт олондоо тавьсан.<br>7. 2022.03.25-ны өдөр "Иргэн бүрд Эрүүл мэнд" аяны Эрүүл зан үйл сэдэвт сургалтыг явуулсан бөгөөд нийт 30 ажилтан танхимаар, 30 ажилтан цахимаар хамрагдсан байна.<br>8. Гар угаах сэдвээр 3 удаа сургалт хийсэн. Дэлхийн гар угаах өдрийг тохиолдуулан иргэдэд мэдээлэл өгч, дэмжих үйлчилгээний 16 асрагчид сургалт хийж | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гардан үйлдлээр шалгасан. Нийт 11 үйлчлэгчээс 5 буюу 45.4% нь зөв дараалаар гараа гүйцэт угаасан байна.<br>9. 2022.04.05-ны өдөр “Эрүүл мэндийн байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээ” сэдвээр халдвар судлаач эмч Г.Долгорсүрэн нийт үйлчлэгч нарт 2 удаагийн онолын мэдлэг олгох, эрүүл мэндийн байгууллагын халдвар, халдварын сэргийлэлтийн чиглэлээр сургалт зохион байгуулсан.<br>10. 2022.04.07-08-ны өдөр “Арьсны өвчтэй хүнд үзүүлэх сувилахуйн тусламж, хэсэг газрын эмчилгээний онцлог“ сэдэвт 1 кр багц цагийн сургалтыг Сувилахуйн алба, Сургалтын алба хамтран цар тахлын дараа анх удаа Улсын хэмжээнд танхим, дадлага хосолсон хэлбэрээр зохион байгуулагдсан, 18 аймгийн арьсны сувилахуйн мэргэжилтэй сувилагч нар хамрагдсан, багц цагийн баталгаажилтыг цахимаар хийсэн зэрэг шинэлэг талтай сургалт зохион байгуулагдав.<br>11. 2022.05 сард “Сармагчны цэцэг өвчний тархалт, урьдчилан сэргийлэлт” сэдэвт сургалтыг халдвар судлаач эмч Г.Долгорсүрэн удирдан явуулав, сургалтад 20 эмч хамрагдсан.<br>12. 2022.05.09, 2022.05.18, 2022.05.20-өдрүүдэд англи хэлний гурван удаагийн цуврал сургалтыг Сургалтын алба АШУҮИС-ийн англи хэлний тэнхимтэй хамтран зохион байгуулсан бөгөөд сургалтад 8 эмч хамрагдсан.<br>13. 2022.05.13-ны өдөр ажлын гүйцэтгэлийн үнэлгээг үнэлэх KPI | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | программын сургалт зохион байгуулагдаж тасгийн эрхлэгч, ахлах сувилагч, албадын дарга, удирдлагууд нийт 30 ажилтан хамрагдсан.<br>14. 2022.05.30-2022.06.06-ны Сургалтын алба АШУҮИС-ийн Эрүүл мэндийн судалгааны тэнхимтэй хамтран өдрүүдэд судалгааны арга зүйн 1 кр сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 62 /эмч нар 30, резидент эмч 32/ хамрагдлаа.<br>15. 2022.06.15-ны "Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлье" чанар сайжруулах аяны хүрээнд "Байгууллагын шинэ соёл" сэдэвт сургалтыг I тасгийн санаачилгаар зохион байгуулж 44 ажилтан, 13 резидент эмч/ хамрагдлаа.<br>16. Эрүүл мэндийн байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээ сэдвээр 12 үйлчлэгч нарт 2 удаа сургалт зохион байгуулсан.<br>17. ЭМС-ын А/505 тушаалын хүрээнд эмнэлгийн ажилчдад “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент” дадлага сургалтыг 3 удаа зохион байгуулж нийт 61 эмч, эмнэлгийн ажилчид хамрагдлаа.<br>18. АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэнд, биостатистикийн тэнхимтэй хамтран Судалгааны арга зүйн цуврал сургалтыг зохион байгуулсан бөгөөд 2022.05.31, 2022.06.03, 2022.06.06 өдрүүдэд Поликлиник, Хэвтэн эмчлүүлэх I, II тасгууд, Лаборатори, ЭЭЯТТ, ЭГЗНСТ, Захиргаа, АӨСҮТ-ийн резидент эмч нийт 73 ажилтан давхардсан тоогоор хамрагдсан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 19. 2022.06.10-11-нд Эрүүл мэндийн чанарын холбоо ТББ-тай хамтран “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал” сэдэвт чанарын сургалт зохион байгуулсан. Сургалтад алба тасгуудын чанарын багийн ахлагч, 23 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>20. 2022.06.22-ны өдөр “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажил”-ийн хүрээнд халдвараас сэргийлэх хяналтын албанаас 3 сэдэвт сургалт зохион байгуулж 25 ажилтан хамрагдсан байна.<br>21. 2022.06.29-ны өдөр “Өртөлт ба өртөлтийн дараах сэргийлэлт” сэдвээр төвийн 25 ажилтанд сургалт зохион байгуулж, ЭМС-ын А/537 тоот тушаалын хүрээнд бэлтгэсэн мэдлэг шалгах сорилыг сургалтын өмнө болон дараах бөглүүлсэн.<br>22. “Үйлчилгээний ажилчдын соёл” сэдвээр сургалт Поликлиникийн тасгийн сувилагч Г.Отгон тасгийн асрагч нарт зохион байгуулсан.<br>23. 2022.09.10-ны өдөр Сургалтын албанаас Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтран Амилуулах тусламжийн 1кр сургалт зохион байгуулж 68 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>24. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлээр 8 шинэ ажилтанд сургалт зохион байгуулсан.<br>25. “Менежментийн тогтолцоонд аудит явуулах” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 26. 2022.10.18-ны өдөр ЭМС-ын А/319 дүгээр тушаалаар “Сувилахуйн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ” сургалт ажилчдыг хамруулсан байна.<br>27. 2022.10.26-ны өдөр Кредиттэй “Ёс зүйн сургалт” цахимаар сургалт зохион байгуулсан байна.<br>28. 2022.11.10-ны өдөр ЭМС-ын А/406 дугаар тушаалаар “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм” сургалтаар ажилчдыг хамруулсан байна.<br>29. Сувилахуйн албанаас “Ахлах сувилагч, сувилагчийг ажлын байранд сургах хөтөлбөр” сэдэвт сургалт зохион байгуулсан.<br>30. 2022.11.21-ний өдөр Хүний эрхийн үндэсний комиссын “Хүний эрхийн мэдрэмж, ажлын байрны дарамт, ажлын байрны үүрэг хариуцлага ялгаа” сургалтуудыг зохион байгуулж кредиттэй сургалтад 58 ажилтан албан хаагч хамруулсан байна.<br>Гадны байгууллагаас зохион байгуулсан дараах сургалтуудад идэвхтэй оролцсон:<br>1. 2022.01.06-ны өдөр “Томуу томуу төст өвчний үед үзүүлэх тусламж, үйлчилгээ” сэдэвт сургалтанд тархвар судлаач<br>2. 2022.01.26-ны өдөр “SARS-COV-2 вирусийн омикрон хувилбарын эсрэг хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах” цахим сургалтад Их эмч Б.Номин, Б.Ганбаяр, С.Билгүүнцоож, Б.Баярмаа, М.Отгонбаяр нар тасаг бүрээс ажил үүргийн зохицуулалт хийн сургалтанд оролцуулж, оролцогчид тасгийн бусад эмч нарт мэдээлэл хүргэж ажиллав | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 3. 2022.01.28-ны өдөр ЭМЯ, ЭХЭМҮТ, СЭМҮТ-ээс зохион байгуулсан “Хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлэхэд түгээмэл тохиолдож байгаа алдаа” сэдэвт, цахим сургалтанд тасгийн эрхлэгч, хэвтэн эмчлүүлэх тасгийн эмч нар хамрагдсан.<br>4. 2022.02.10-ны өдөр ЭЭХХЗГ-ын Эмийн аюулгүй байдлын тандалт, судалгааны газраас зохион явуулсан “Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг сайжруулах” сэдэвт хэлэлцүүлэгт эмнэл зүйн эм зүйч С.Пүрэвсүрэн оролцсон<br>5. Дижитал Медик ХХК, ЭМХТөвөөс зохион байгуулсан “Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан программ хангамж” сургалт IT инженер Ганзориг хамрагдсан<br>6. 2022.03.02-ны өдөр Баянгол мед ХХК-аас зохион байгуулсан коагулограмын аппарат ашигдах зааврын сургалтанд лабораторийн тасгийн ихх эмч А.Дулмаа хамрагдаж авсан олж авсан мэдлэгээ тасгийн хамт олондоо 2022.03.03-ны өдөр танилцуулсан.<br>7. 2022.03.24-ны өдөр ШУГТЭ "Гематологийн шинжилгээний 27 дахь биохимийн шинжилгээний 21 дэх, цусны бүлэг тохиргооны 16 дахь удаагийн удаагийн чанарын гадаад үнэлгээний ур чадварын үнэлгээ ба стандарчлал" сэдэвт тайлан семинарт лабораторийн эмч А.Дулмаа хамрагдсан.<br>8. 2022.03.25-ны өдөр Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, иргэдийн хэрэглээний боловсролын төвөөс зохион байгуулсан “Иргэн бүрт эрүүл мэнд” аяны хүрээний эрүүл мэндийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтад эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>9. Өмгөөлөл Лого Стратеги” ХХК-ний гүйцэтгэх захирал О.Бэлгүүнзаяа Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн харилцаа, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх удирдлагын тогтолцоо, Хууль эрх зүйн үндэслэл үйлдвэрийн ослыг судлан бүртгэх, Ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ /ЗГ-ийн 269 дүгээр тогтоол/ сэдвээр Тасаг, албадын дарга, эрхлэгч нийт 116 ажилтанд сургалт зохион байгуулсан.<br>10. 022.04.11-ны өдөр ЭМХТ-өөс зохион байгуулсан “Халдварт өвчний эрт илрүүлэг” сэдэвт цахим сургалтанд лабораторийн тасгийн эрхлэгч Ж.Энхжаргал, их эмч А.Дулмаа эмч нар хамрагдсан.<br>11. 2022.04.14-ны өдөр Гедеон рихтер ХХК, Сонгдо эмнэлгийн зүрх судас, ангиографийн эмч Ц.Намхайдорж хамтран “Post-covid management” сэдэвт сургалтыu АӨСҮТ-ийн хурлын танхимд зохион байгуулж сургалтад 32 эмч хамрагдсан.<br>12. 2022.04.18-20-ны өдрүүдэд ЭМЯ-аас зохион байгуулсан “Байгууллагын архивын баримтын цахимжуулалт, тоо бүртгэл, хадгалалт, хамгаалалт, ашиглалт" сэдэвт сургалтад Архивын ажилтан Т.Мөнхцацрал хамрагдсан. Сургалтын үр дүнд байгууллагын архивын баримтын цахимжуулалт, тоо бүртгэл, хадгалалт, хамгаалалт, ашиглалтаар мэргэшиж 24 цаг бүхий батламж авсан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 13. 2022.04.19-.20-ны өдрүүдэд "Эрүүл мэндийн байгууллагын цахим ур чадварыг хөгжүүлэх нь" сэдэвт сургалтад Гүйцэтгэх захирал Ц.Уранчимэг, ҮАЭДЗ Т.Баярмаа, ЭЭДЗ Б.Батцэцэг, МТА дарга Б.Ганзориг нар. оролцсон.<br>14. 2022.04.25-ны өдөр ЭМЯ-аас зохион байгуулсан "Эрүүл мэндийн салбарт хүүхэд хамгааллын үйлчилгээнд тулгамдсан асуудал" сэдэвт сургалтад хүүхдийн хэвтэн эмчлүүлэх тасгийн Б.Золбаяр эмч хамрагдсан.<br>15. 2022.05.02-ны өдөр ЭМЯ-аас зохион байгуулсан Цалингийн гүйлгээг цахимжуулах ажлын хүрээний сургалтад санхүү, эдийн засгийн албаны Б.Мядаг нягтлан бодогч Б.Ууганчимэг нар хамрагдсан.<br>16. 2022.05.09-ны өдөр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зохион байгуулсан Улаанбаатар хот дахь төрийн өмчит хуулийн этгээдийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга, үндсэн хөрөнгө хариуцсан нягтлан, нярав нарт зориулсан сургалтанд аж ахуйн албаны дарга Т.Мөнхцацрал, нягтлан бодогч А.Сэлэнгэ хамрагдсан<br>17. 2022.05.10-11-ны өдрүүдэд "Хавдрын үеийн сувилахуйн тусламж, үйлчилгээ" үндэсний хэмжээний сургалтанд Сувилахуйн албаны дарга Ө. Ариунаа, хүүхдийн тасгийн ахлах сувилагч Х. Эрдэнэтуяа, клиникийн I тасгийн ахлах сувилагч Б. Жавхлант нар оролцсон..<br>18. 2022.05.12-ны өдөр Монгол Улсын их хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн санаачлилгаар зохион байгуулсан | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | “СУВИЛАГЧИД ЭЭЛТЭЙ МОНГОЛ” 2022 сувилахуйн чуулга уулзалтанд хүүхдийн тасгийн ахлах сувилагч Х. Эрдэнэтуяа, I-р тасгийн ахлах сувилагч Б. Жавхлант, Эрчимт эмчилгээ яаралтай тусламжийн тасгийн сувилагч Т. Оюунбилэг, II-р тасгийн сувилагч У. Хажидмаа нар оролцсон.<br>19. 2022.05.18-2022.05.21- ны өдрүүдэд “Корона вируст халдвар/ковид-19/-халдварын дараах сэргээн засах тусламж, үйлчилгээ болон Олон улсын жишигт нийцсэн орчин үеийн сэргээн засах тусламж, үйлчилгээний чиг хандлага" сэдэвт багц цаг олгох сургалтад ЭГЗНСТасгийн их эмч И.Мөнхзаяа оролцсон.<br>20. 2022.05.19-20-ны өдрүүдэд ЭМЯ болон ХӨСҮТ-ийн хамтарсан “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент” сэдэвт 2 өдрийн сургалтад халдвар судлаач Г.Долгорсүрэн хамрагдсан.<br>21. 2022.05.26-ны өдөр Төрийн албаны зөвлөл, Монголын оюун ухааны академи хамтран зохион байгуулсан “Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 арга зүй” сургалтанд 10 ажилтан цахимаар харагдсан.<br>22. 2022.05.27-ны өдөр “Эмгэг судлалын лабораторийн дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх нь” сэдэвт сургалтанд лаборант Х.Гэрэлсүрэн хамрагдсан.<br>23. 2022.06.08-ны өдөр МЭМАҮЭ-ийн холбооны хөдөлмөрийн аюулгүй байдал, галын аюулгүй байдал хариуцсан 28 эмч, эмнэлгийн ажилтанд | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | АӨСҮТ-ийн ХАБЭАжилтанд сургалт явуулсан.<br>24. 2022.06.08- ны өдөр “Байгууллагын сургалт хөгжлийг шийдэх гарц, Хамт олныг хэрхэн мотивацижуулах вэ сэдвээр илтгэгч Э.Чинзоригийн сургалтад Хүний нөөцийн албаны дарга Б.Пүрэвцэцэг хамрагдсан<br>25. 2022.06.10,11,12- ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Цахим орчинд эрсдэлийн үеийн мэдээллийг үнэлэх, контент бэлтгэх, хөгжүүлэх, түгээх чадварыг нэмэгдүүлэх” онол, практикийн хослосон сургалтад НЭМА Х.Хэрлэн оролцсон.<br>26. 2022.06.15-ны өдөр "Байгууллагын шинэ соёл" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 44 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, 13 резидент эмч нар хамрагдсан.<br>27. 2022.06.09-ны өдөр Legal Service Center хууль зүйн үйлчилгээний төвөөс Хөдөлмөрийн шинэчлэгдсэн хуулийн гол өөрчлөлтүүд, албан тушаалын тодорхойлолт дахь хөдөлмөрийн аюулгүй байдал сэдэвт сургалтад ХНАДарга Б.Пүрэвцэцэг хамрагдсан.<br>28. Ажлын эмх цэгц, минимал амьдралын хэв маяг, цаг төлөвлөлт хувийн зохион байгуулалт сэдвээр захиргааны 20 ажилтан хамрагдсан.<br>29. 2022.06.10-12-ны өдрүүдэд ЭМЯ-ны Нийтийн эрүүл мэндийн газар, Халдварт өвчний хэлтсээс зохион байгуулсан “Цахим орчинд эрсдэлийн үеийн мэдээллийг үнэлэх, контент бэлтгэх, хөгжүүлэх, түгээх чадварыг нэмэгдүүлэх” онол, практикийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хослуулсан сургалтад Сургалтын албаны НЭМА Х.Хэрлэн хамрагдсан. Сургалтад харилцааны ур чадвар, камер ашиглах, мэргэжлийн зураг авах арга техник, багаар ажиллах, хэвлэлийн тойм, мэдээлэл түгээх арга аргачлал гэх зэрэг сэдвүүдээр сургалтад хамрагдсан.<br>30. 2022.06.17-ны өдөр Монголын харшил судлалын нийгэмлэгийн 18-р чуулганд их эмч Б.Энхсайхан хамрагдсан.<br>31. АӨСҮТ-н Эм зүйн алба нь ЭЭХХЗГ-аас зохион явуулсан “Эмийн аюулгүй байдлын идэвхтэй тандалтын сарын аян”-д оролцож улсын болон хувийн хэвшлийн нийт 70 гаруй эмнэлгүүдээс 3-р байрт шалгарсан.<br>32. 2022.06.21,22,23-ны өдрүүдэд сувилахуйн “Эмнэл зүйн сургагч багш”-ийн сургалтанд Сувилагч А.Дэжидмаа хамрагдсан.<br>33. 2022.06.27-ны өдөр Шилэн дансны системийн шинэчлэлийн сургалтанд санхүүгийн албаны дарга Б.Мядаг цахимаар оролцсон.<br>34. 2022.06.28-ны өдөр АУШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэг, ХӨСҮТ хамтран зохион байгуулсан “Эмнэлгийн халдварын сэргийлэлт хяналт-Олон улсын жишиг тогтолцоо” сэдэвт сургалтанд халдвар судлаач Г.Долгорсүрэн, чанарын албаны дарга Б.Баярмаа нар хамрагдсан.<br>35. 2022.06.29-ны өдөр Ковид-19 оношлуур, хэрэгслийн орлого, зарлагын мэдээллийг www.burtgel.mohs.mn сайтад оруулах зааварчилгаа сургалтанд эм зүйн албаны дарга Э.Мөнхгэрэл, лабораторийн тасгийн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эрхлэгч Ж.Энхжаргал, лаборант У.Буманзаяа нар цахимаар хамрагдсан.<br>36. 2022.06.30-ны өдөр Цусны донорын тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт их эмч Б.Амаржаргал цахимаар оролцсон.<br>37. 202.09.08-09-ний өдрүүдэд стандарт хэмжилзүйн газраас зохион байгуулсан “MNS ISO 9001:2016 ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО-ШААРДЛАГА” сэдэвт сургалтанд ЭМТҮЧАБА-ны дарга Б.Баярмаа, Сургалтын албаны дарга Б.Лхагвасүрэн нар хамрагдаж, гэрчилгээ гардан авлаа.<br>38. 2022.09.15-16-ны өдрүүдэд Монголын радиологийн нийгэмлэгээс зохион байгуулсан “Хавдрын дүрс оношилгоо” сэдэвт 2 багц цагийн сургалтанд дүрс оношилгооны их эмч Б.Лхагвасүрэн оролцсон.<br>39. 2022.09.22-ны өдөр ЭМЯ-ны эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооноос зохион байгуулсан “Эрүүл мэндийн судалгаанд ёс зүй, Эмнэлзүйн зохистой дадал, үйл ажиллагааны судалгааны онол, практикийн асуудал” сэдэвт сургалтанд АӨСҮТ-ийн эрдмийн зөвлөлийн дарга Ц.Уранчимэг, эрдэмтэн нарийн бичгийн дарга Б.Лхагвасүрэн нар оролцсон.<br>40. Үйл ажиллагаа эрхэлсэн захирал Т.Баярмаа эрүүл мэндийн удирдлагын мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан.<br>41. Эмчилгээний гоо сайхан нөхөн сэргээх тасгийн туслах сувилагч Н.Мөнхтогоо гоо заслын сургалтад хамрагдсан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 42. Программ хангамжийн инженер Б.Дөл систем хөгжүүлэлтийн сургалтад хамрагдсан.<br>43. Төрийн худалдан авах ажиллагааны А3 гэрчилгээ олгох сургалтад программ хангамжийн инженер Б.Дөл, эдийн засагч Б.Амарзаяа, лабораторийн их эмч н.Сүхболд, аж ахуйн тасгийн дарга Т.Мөнхцацрал нар хамрагдсан байна.<br>44. 2022.12.07-08-ны өдөр “Эрүүл мэндийн салбарын цахим системийн хэрэглээ ба статистик мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, төлөвлөлтөнд ашиглах чадавхийг нэмэгдүүлэх” сургалтад гүйцэтгэх захирал, статисткич эмч, мэдээлэл технологийн албаны дарга нар хамрагдсан.<br>45. 2022.12.07-08-ны өдөр “Эрүүл мэндийн ажилчдын салбарын эдийн засагч, санхүүчдийн төсвийн төлөвлөлт санхүүгийн тайлангийн ажлын уялдааг сайжруулах мэргэжилт арга зүйгээр хангах” сургалтад Санхүүгийн алба, эдийн засагч нар хамрагдсан.<br>46. 2022.12.13-ны өдөр “БЗД, ХДХВ, ДОХ-ын тусламж үйлчилгээний чанар заавар” нэмэлт өөрчлөлт оруулах талаар сургал тархвар судлаач н.Долгосүрэн хамрагдсан.<br>47. 2022.12.16-ны өдөр “Эмгэг судалын тусламж үйлчилгээ-2022” зөвлөгөөн Их эмч Э.Дэлгэрзаяа хамрагдсан.<br>48. 2022.12.16-17-ны өдрүүдэд Монголын Сувилагчдын нийгэмлэгээс “Удирдлагын манлайлал” сэдэвт сургалт сувилагч н.Хажидмаа, н.Оюунтуяа тус тус хамрагдсан байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | III. 2022 онд 8 эмч, эмнэлгийн ажилтан зэрэг хамгаалсан:<br>- Тэргүүлэх зэрэг их эмч-1 (Ж.Энхжаргал),<br>- Ахлах зэрэг их эмч-3 (М.Амаржаргал, Ө.Дугармаа, Б.Оюунцацрал)<br>- Тэргүүлэх зэрэг сувилагч-2 (Б.Оюунтуяа, Х.Эрдэнэтуяа),<br>- Тэргүүлэх зэрэг батлах-2 (Ч.Цэрэннадмид, Ө.Ариунаа)<br> <br>IV. Нийт 16 эмч, эмнэлгийн ажилчид эрдэм шинжилгээний хуралд амжилттай оролцлоо. Үүнд:<br>- АШУҮИС-ийн “Эрдмийн чуулган-64”, нийгмийн эрүүл мэнд, төгсөлтийн сургалтын салбар хуралдаан 2022-04-07 өдөр зохион байгуулагдсан бөгөөд Эмчилгээ эрхэлсэн дэд захирал Б.Батцэцэг, сургалтын албаны дарга Б.Лхагвасүрэн нарын илтгэл 90 гаруй илтгэлээс шилдгээр шалгарсан ба аман илтгэлийн хэлэлцүүлгээс Эмчилгээ эрхэлсэн дэд захирал Б.Батцэцэгийн илтгэл дэд байр эзлэн 5,000,000 төгрөг, гадаадын хэвлэл өгүүлэл хэвлүүлэх эрхээр шагнуулж амжилттай оролцлоо.<br>- 2022.05.29-нд Арьс судлаачдын монголын нийгэмлэгээс зохион | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байгуулсан “Арьс судлаачдын монголын нийгэмлэгийн хаврын эрдэм шинжилгээний хурал-VI”-д АӨСҮТ-ийн 11 эмч (Б.Батцэцэг, Б.Номин, С.Солонго, Ч.Эрдэнэчимэг, М.Мөнгөнтүлхүүр, У.Саруул, О.Урангоо, Х.Энхжин, Б.Энхсайхан, О.Билгүүнцоож, Ж.Энхжаргал) хамрагдсан.<br>- 2022.06.16-нд АӨСҮТ-ийн Эрдэм шинжилгээний “Эрдмийн чуулган VI” хурал зохион байгуулагдсан. Тэргүүн байранд Э.Мөнхгэрэл /Эм зүйн албаны дарга/ “Дотуур хэрэглэсэн бодисын шалтгаант дерматит өвчний эмийн хэрэглээ” илтгэл, дэд байранд Б.Баярмаа /ЭМТҮЧАБ албаны дарга/ - “Тусламж, үйлчилгээний чанар сайжруулахад ижил мэргэжилтний үнэлгээний оролцоо” илтгэл, эмнэлзүйн тохиолдлын дэд байранд: У.Саруул /эрчимт эмчилгээний их эмч/ “Арьсны эвэршдэг эсийн хавдартай өвчтөнд паранеопластик цэврүүтэлт оношилсон нь” эмнэлзүйн тохиолдлоор тус тус шалгарсан.<br><br>- 2022.06.17-ны өдөр Монголын харшил судлалын нийгэмлэгийн 18-р чуулганд их эмч Б.Энхсайхан хамрагдсан.<br>V. Удирдах ажилтнуудыг чадавхжуулах, манлайллыг хөгжүүлэх мөн ажилтан, албан хаагчдыг мэргэжлийн ур чадвар болон хувь | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүний түвшинд сурч хөгжихөд дэмжлэг үзүүлэх, сурч хөгжих хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх, түлхүүр ажилтнуудын залгамж халааг бэлтгэх, байгууллагын дотоод соёл, эерэг хандлагыг бий болгох зорилгоор дэвшилтэт технологи, шинэ санаа нэвтрүүлэн, үр ашигтай ажилласан эмч, эмнэлгийн ажилтныг урамшуулж ажилласан. Үүнд: Засгийн газрын төрийн дээд шагналаар 10, бусад шагналаар 69 ажилчид шагнуулсан:<br>1. МУ-ын Хүний гавьяат эмч-1 /Зөвлөх их эмч Б. Хандсүрэн/<br>2. Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон 2 ажилтан /Гүйцэтгэх захирал Ц.Уранчимэг/ АӨСҮТөвийн харшил судлалын төв лабораторийн эрхлэгч, биологийн шинжлэх ухааны доктор, профессор Б.Сангидорж<br>3. Алтан гадас-3 ажилтан / Их эмч Г.Баянжаргал, Эм зүйч Р. Энхчимэг, ахлах сувилагч Б.Батцэцэг<br>4. Хөдөлмөрийн хүндэт-4 /Их эмч Б.Амаржаргал, сувилагч Ж.Тунгалаг, тогооч Н. Оюунцэцэг, асрагч С. Оюунцэцэг/ шагнагдсан байна.<br>5. МЭМАҮЭ-ийн холбооны "АЛТАН ЧАГНУУР"-1 их эмч /Поликлиникийн тасгийн эрхлэгч, МУ-ын зөвлөх зэрэгтэй Г.Цогзол/<br>6. Эрүүл мэндийн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн медаль-32 ажилтан.<br>7. ЭМЯ-ны Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан-2 /Асрагч Г.Пүрэвдорж, Тогооч Р.Энхжаргал<br>8. ЭМЯ-ны “Жуух бичиг”-9 /Ахлах сувилагч Б.Жавхлант, Сувилагч Э.Энхцэцэг, Угаагч Л.Наранчимэг, Их эмч Б.Энхсайхан, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Биохимич Б.Баярлхагва, Сувилагч Я.Будханд, Лаборант Ш.Хишигсүрэн, Лаборант Г.Дэнсмаа, Сувилагч Г.Отгонзул/<br>9. Ардын хувьсгалын 100 жилийн ойн медаль-25 эмч, сувилагч тусгай мэргэжилтнүүд тус тус шагнагдсан байна.<br>Дээрх алба хаагчдад Төрийн болон засгийн газрын шагналаар шагнагдсан мөн байгууллагад идэвх санаачилгатай ажилласан алба хаагчдыг нийт 21,870,378 /хорин нэгэн сая найман зуун далан мянга гурван далан найм/ төгрөгөөр шагнаж урамшуулсан бол сарын үндсэн цалингаар 1, 2 ажилтныг 3 сарын үндсэн цалингийн 40 хувь, 25 ажилтныг сарын үндсэн цалингийн 10-50 хувиар тус тус шагнаж урамшуулсан байна. | |
| 28. | 4.1.2 | МУТЖҮЧ-5.4.1. Арьс, гоо заслын эмчийн резиденсийн сургалтыг зохион байгуулж, арьс гоо заслын эмчийг бэлтгэнэ. | 30 /улсын төсөв, өөрийн орлого/ | Шинээр бэлтгэгдсэн арьс, гоо заслын эмчийн тоо | Арьс, гоо заслын 18 мэргэжилтэн бэлтгэгдсэн байна. | Жилийн турш | 2022-2023 оны хичээлийн жилд 35 резидент эмч арьсны үндсэн мэргэшлийн төгсөлтийн дараах сургалтад суралцаж байна. Үүнд:<br>1. 2022-2024 онд суралцах 16 резидент эмч ЭМС-ын 2022 оны 10 сарын 06-ны өдрийн А/479 тушаалаар элсэн суралцаж байна.<br>2. 2021-2023 онд суралцах 19 резидент эмч<br>2020-2022 онд суралцаж, төгссөн 18 резидент эмч ЭМС-ын 2022 оны 12-р сарын 01-ны өдрийн А/574 тушаалын дагуу 100% амжилттай төгслөө.<br>Сургалт эрхлэх байгууллагын хүрээнд эрх бүхий байгууллагын сургалт эрхлэх зөвшөөрөл, магадлан итгэмжлэлийн тавигдах хүчин төгөлдөр мөрдөгдөх шаардлагад нийцүүлэн сургалтын үйл | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллагааг тогтмол сайжруулан шинэчлэх, суралцагч, захиалагч байгууллагын хэрэгцээг хангах хүний нөөцийг бэлтгэн сургах, чадавхижуулах, резидент эмчийн сургалтын үйл ажиллагааг сайжруулахаар резидент эмч тус бүр чиглүүлэгч багш томилон “ментор-менти” арга барилыг 2022 оны 2 сараас нэвтрүүлсэн. Нийт 13 эмнэл зүйн сургагч багш/менторт 36 резидент эмч/менти-г 2-3 хувиарласан. Хувиарлалтын дагуу менторууд өөрийн хариуцсан резидент эмчийн тойролт хянаж, чиглүүлж байна<br>Арьс судлал үндсэн мэргэшил эзэмшүүлэх сургалтын дэвтрийг холбогдох багш нарын санал, зөвлөмжийн дагуу шинээр боловсруулж, ЭМХТ-ийн мэргэжилтнээр хянуулан, төвийн захирлаар батлууж, нийт резидент эмч нар хүлээлгэн өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br> | |
| 29. | 4.1.3 | МУТЖҮЧ-5.4.1. Арьсны эмч, мэргэжилтний мэргэшлийн ур чадварыг | 10 /өөрийн орлого/ | Сургалтад хамрагдсан эмч, эмнэлгий | Квотын дагуу урт, богино хугацааны сургалтыг зохион | Жилийн турш | ➢ 2022 онд төрөлжсөн нарийн мэргэжлээр 6 эмч, 3 лаборант, сувилахуйн төрөлжсөн нарийн мэргэжлийн чиглэлээр 2 сувилагч мэргэжил дээшлүүлсэн. Үүнд:<br>1. Эмгэг судлаач их эмч-1<br>2. Арьс судлал мэргэжил дээшлүүлэх-2 эмч | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дээшлүүлэх урт, богино хугацааны сургалтуудыг зохион байгуулна. | | н мэргэжилтний тоо | байгуулсан байна. | | 3. Харшил судлал-3 эмч<br>4. “Арьсны сувилахуй” төрөлжсөн мэргэшлийн сургалтад 5 сувилагч<br>5. Эмчилгээний гоо заслын сувилахуйн төрөлжсөн мэргэшлийн сургалтанд 5 сувилагч<br>6. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Дархлаа судлалын техникчийн төрөлжсөн мэргэшлийн сургалтад иммунологийн чиглэлээр 1 лаборант<br>7. Мөөгөнцрийн техникчийн 1 сарын хугацаатай сургалтад 2 лаборант<br>8. Эмнэл зүйн дархлаа судлалын сувилахуй чиглэлээр 1 сувилагч<br>9. УГТЭ-ийн мэс заслын сувилахуйн төрөлжсөн мэргэшлийн сургалтад 1 сувилагч<br>➢ Арьсны эмч, мэргэжилтний мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор төвийн хэмжээнд болон гадны байгууллагатай хамтарсан нийт 14 чиглэлийн сургалтыг зохион байгуулж нийт давхардсан тоогоор 130 ажилчдыг хамруулсан.<br>1. ЭМЯ, ЭМХТ, Япон Улсын Хамтын ажиллагааны Жайка байгууллагаас зохион байгуулсан “Эмнэлзүйн сургагч багш”-аар 1 сувилагч /Ч.Дэжидмаа/ суралцаж төгссөн.<br>2. АӨСҮТөв “Арьсны өвчтэй хүнд үзүүлэх сувилахуйн тусламж, хэсэг газрын эмчилгээний онцлог“ 1 кр багц цагийн сургалт зохион байгуулсан. Сургалтад АӨСҮТ-ийн нийт сувилагч нар хамрагдсан.<br>3. Сармагчны цэцэг өвчний талаарх сургалтад 20 эмч.<br>4. 2022.03.02-нд “Баянгол Мед”-ээс зохион байгуулсан коагулограмын аппарат | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ашиглах зааврын сургалтад лабораторийн тасгийн их эмч<br>5. "Арьсны өвчтэй хүнд үзүүлэх сувилахуйн тусламж, хэсэг газрын эмчилгээний онцлог" сэдэвт сургалт зохион байгуулав.<br>6. Эрүүл мэндийн сайдын А/814 дугаар тушаалын дагуу шинэчилсэн "Яаралтай тусламжийн эрэмбэлэн ялгалт" сэдвээр АӨСҮТөвийн нийт эмч нар болон ЭМХТ болон АШУҮИС-ийн I болон II дугаар дамжааны резидент эмч нарт ЭЭЯТТасгийн их эмч У.Саруул сургалт зохион байгууллаа.<br>7. 2022.02.25-нд АШҮУИС болон “Фройка ХХК”-аас зохион байгуулсан “Хайрст үлдийн шинэ эмчилгээний удирдамж болон биологийн бэлдмэлийн эмнэлзүйн тохиолдол” сургалтад “Секукинумаб биологийн бэлдмэлийг хэрэглэх үеийн өвчтөний хяналт” сэдэвт лекцийг зөвлөх эмч Г.Цогзол удирдан явуулсан, сургалтад нийт эмч нар цахимаар хамрагдсан.<br>8. “Хавдрын үеийн сувилахуйн тусламж үйлчилгээ” үндэсний хэмжээний 2 өдрийн сургалтад Сувилахуйн албаны дарга Ө. Ариунаа, хүүхдийн тасгийн ахлах сувилагч Х. Эрдэнэтуяа, I-р тасгийн ахлах сувилагч Б. Жавхлант нар хамрагдлаа<br>  | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 9. ЭМХТ-өөс зохион байгуулсан “Томуу томуу төст өвчний үед үзүүлэх тусламж үйлчилгээ” сэдэвт сургалтад халдвар судлаач хамрагдсан<br>10. НЭМГ, ЭМЯ-аас зохион байгуулсан SARS-COV-2 вирусийн о микрон хувилбарын эсрэг хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангахад чиглэсэн сургалтад 5 эмч цахимаар хамраагдсан.<br>11. ЭМЯ, ЭХЭМҮТ, СЭМҮТ-с зохион байгуулсан “Хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлэхэд түгээмэл тохиолдож байгаа алдаа” сургалтад тасгийн эрхлэгч, хэвтэн эмчлүүлэх тасгийн эмч нар цахимаар хамрагдсан<br>12. ЭМХТ-өөс зохион байгуулсан “Халдварт өвчний эрт илрүүлэг” сэдэвт сургалтад лабораторийн эмч Ж.Энхжаргал, А.Дулмаа нар цахимаар хамрагдсан<br>13. Гедеон рихтер ХХК-аас “Пост-ковид менежмент” сэдэвт сургалтыг төвийн 32 их эмч хамрагдсан.<br>14. ЭМЯ-аас зохион байгуулсан “Корона вируст халдвар /КОВИД-19/-ын дараах сэргээн засах тусламж, үйлчилгээ болон Олон Улсын жишигт нийцсэн орчин үеийн сэргээн засах тусламж, үйлчилгээний чиг хандлага" сэдэвт сургалтад ЭГЗНСТасгийн 1 их эмч хамрагдсан.<br><br>➢ Гадаадын өндөр хөгжилтэй оронд мэргэжил дээшлүүлэх сургалтад нийт 4 эмч хамрагдаж байна:<br>1. Арьс, харшлын эмч, мэргэжилтний мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор ОХУ-ын РУДН их сургууль, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Арьс өнгөний нийгэмлэгийн хамтарсан харшлын мэргэжил дээшлүүлэх сургалтад хувийн зардлаар 1, байгууллагын зардлаар нийт 2 эмч суралцаж төгссөн.<br>2. Эмчилгээний гоо засал, нөхөн сэргээх чиглэлээр мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Seoul National University Hospital /Сөүлийн Үндэсний Их Сургуулийн Эмнэлэгт 1 сарын хугацаатай сургалтад эмчилгээний гоо засал нөхөн сэргээх тасгийн 1 их эмч хамрагдсан.<br>3. БНСУ-ын Сөүл хотод 2022.12.02-12.04-ны хооронд зохион байгуулагдсан APAAS ОУХ-д арьсны чиглэлээр 2 их эмч хувийн зардлаар оролцов. | |
| 30. | 4.1.4 | ЗГҮАХ-2.1.4.2. Сувилагч мэргэжилтнүүдийг яаралтай амь тэнссэн үеийн тусламж үзүүлэх чадавхид сургана. | 0.5 /өөрийн орлого/ | Эмч, мэргэжилтний сургалтад хамрагдалтын хувь | Сувилагч, мэргэжилтнүүдийн 90-ээс дээш хувь амь тэнссэн үеийн сургалтад хамрагдсан байна. | 3,4 улирал | ЭМХТ болон АШУҮИС-ын 1, 2 дугаар курсийн резидент эмч нарт “Суурь болон лавшруулсан яаралтай тусламж” сэдвээр сургалт явуулав. (2022/5/6)<br><br>АСМН, Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтран зохион байгуулсан Амь тэнссэн үеийн эмнэлгийн анхны тусламж сэдэвт сургалтад их эмч С.Солонго хамрагдан сурсан мэдлэгээ тасгийн эмч, сувилагч нартай хуваалцсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |  2022.09.10-ны өдөр Сургалтын албанаас Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтран Амилуулах тусламжийн 1 кр сургалт зохион байгуулж 68 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Ахлах сувилагч Дэжидмаа, сувилагч Хаш эрдэнэ нарыг "Ажлын байранд сургах" хөтөлбөрийг 11-р сарын 14-нөөс 12-р сарын 14 хүртэл яаралтай болон эрчимт эмчилгээний тоног төхөөрөмж дээр ажиллах, шээлгүүр тавих, пампыг ажиллуулах, амилуулах суурь тусламж, эрчимт эмчилгээний хяналтын хуудас хөтлөх зэрэг сургалтыг зааж сургалаа | |
| 31. | 4.1.5 | МУТЖҮЧ-5.4.1. Шинэ ажилтныг чиглүүлэн сургах хөтөлбөр хэрэгжүүлэн, ажлын байранд дадлагажуулна. | - | Сургалтын хөтөлбөр, тайлан Чиглүүлэн сургасан ажилтны тоо | Шинээр ажилд орсон нийт ажилчдыг чиглүүлэн сургаж дадлагажуулсан байна. | Жилийн турш | Шинээр ажилд орсон эмч, эмнэлгийн ажилтантай хөдөлмөрийн гэрээ хийн, гүйцэтгэх захирлын тушаал, албан тушаалын тодорхойлолтыг танилцуулан баталгаажуулан, хувийн хэргийн бүрдлийг бүрдүүлэн, шинэ ажилтныг чиглүүлэх сургалтад хамруулан, байгууллагын фейсбүүк хуудсанд шинэ ажилтныг танилцуулан ажиллаж байна. Шинэ ажилтныг чиглүүлэн сургах хөтөлбөрт шинээр орсон 49 ажилтнаас 28 ажилтныг байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичиг, дүрэм журам, ёс зүй, хөдөлмөрийн аюулгүй байдал, чанарын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | аюулгүй байдал, халдвар хамгаалал, программ хангамж, чанар, сувилахуйн чиг үүргийн дагуу сургалт орж, ажлын байран дээр тасаг нэгжийн ахлах сувилагч, тасгийн эрхлэгч эмч эмнэлгийн мэргэжилтнүүд дараах шинэ ажилтнуудад чиглүүлэх сургалтыг хийсэн. Үүнд:<br>- Сургалтын албаны дарга-1<br>- Хүний нөөцийн албаны дарга-1<br>- Мэдээлэл технологийн албаны дарга-1<br>- Чанарын албаны дарга-1<br>- Их эмч-5 /Үндсэн эмч-2, гэрээт их эмч-3/<br>- Сувилагч-5 /Үндсэн сувилагч-2, гэрээт сувилагч-2/<br>- Эдийн засагч-1<br>- Даатгал хариуцсан ажилтан – 1<br>- Нягтлан -2<br>- Кассын нярав-1<br>- Нярав-2<br>- Цахим бүртгэлийн гэрээт ажилтан-2<br>- Эм зүйч-1<br>- Жолооч-2<br>- Чанарын албаны менежер -1<br>- Жор баригч-1 | |
| *Зорилт 4.2. Гүйцэтгэлийн удирдлагын оновчтой тогтолцоог хэрэгжүүлэх* | | | | | | | | |
| 32. | 4.2.1 | МУУХХБ-5.4.2. Ажлын байрны дүн шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулна. | 0.2 /өөрийн орлого/ | Шинээр боловсрусан албан тушаалын тодорхойлолтын тоо | Нийт 154 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан байна. | Жилийн турш | Төвийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөтэй уялдуулан эмч, эмнэлгийн ажилтнуудын ажил үүргийн хуваарийг тодорхой болгож нийт 86 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулан баталгаажуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.<br>- Захиргааны ажилтны 20 албан тушаалын тодорхойлолт<br>- Лабораторийн тасгийн 15 албан тушаалын тодорхойлолт | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Эмзүйн албаны 6 албан тушаалын тодорхойлолт<br>- Аж ахуйн албаны 7 албан тушаалын тодорхойлолт<br>- Асрагч нарын 3 албан тушаалын тодорхойлолт<br>- Клиникийн тасгуудын 14 албан тушаалын тодорхойлолт<br>- Поликлиникийн тасгийн 15 албан тушаалын тодорхойлолт<br>- Хоол үйлдвэрлэлийн тасгийн 4 албан тушаалын тодорхойлолт<br>- Тасгийн эрхлэгч, ахлах сувилагчийн албан тушаалын тодорхойлолт 2 -ыг шинэчлэн боловсруулсан. | |
| 33. | 4.2.2 | МУУХХБ-5.4.2. Гүйцэтгэлийг чанар, үр дүнтэй уялдуулан урамшуулал олгоно. | 240 /өөрийн орлого/ | Ажилтнуудын сэтгэл ханамжийн түвшин | Гүйцэтгэлийг чанар, үр дүнтэй уялдуулан урамшууллыг олгосон байна. | Жилийн турш | Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирлын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/26 дугаар тушаалаар төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтний гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулж батлуулан kpi.derma.gov.mn-ээр гүйцэтгэлийг чанар, үр дүнтэй уялдуулан үнэлж эхлээд байна.<br>➢ Эхний хагас жилийн гүйцэтгэлийн урамшуулалд 144 ажилтанд 131,417,546 /нэг зуун гучин нэгэн сая дөрвөн зуун арван долоон мянга таван зуун дөчин зургаа/ төгрөгийн урамшуулал олгосон.<br>➢ 3 дугаар улирлын гүйцэтгэлийг урамшуулалд 134 эмч, эмнэлгийн ажилтанд 78,850,534 /далан найман сая найман зуун тавин мянга таван зуун гучин дөрөв/ төгрөг,<br>➢ 10, 11 дүгээр сарын гүйцэтгэлийн урамшуулалд 137 эмч, эмнэлгийн ажилтанд 61,768,365 /жаран нэгэн сая | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | долоон зуун жаран найман мянга гурван зуун жаран тав/ төгрөг нийт 272,036,445 /хоёр зуун далан хоёр сая гучин зургаан мянга дөрвөн зуун дөчин тав/ төгрөгийн урамшуулал олгосон байна.<br>➢ Оны сүүлийн 12 дугаар сарын урамшууллын он гаргаад 01 дүгээр сард үнэлж олгохоор ажиллаж байна. | |
| *Зорилт 4.3. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцааны соёл, хариуцлагыг дээшлүүлэх* | | | | | | | | |
| 34. | 4.3.1 | МУТЖҮЧ-5.4.3. Эмч, эмнэлгийн ажилчдын ёс зүй, сахилга, хариуцлагыг сайжруулах аян зохион байгуулна. | 0.2 /улсын төсөв/ | Баталсан төлөвлөгөө, удирдамж Ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдлын тоо | Эмч, эмнэлгийн ажилчдын ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдолгүй ажилласан байна. | Жилийн турш | Эмч, эмнэлгийн ажилчдын ёс зүй, сахилга, хариуцлагыг сайжруулах аяны хүрээнд бусад эрүүл мэндийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч 5 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 145 ажилтан хамрагдлаа. Үүнд.<br>1. 2022.06.10,11-нд Эрүүл мэндийн чанарын холбоо ТББ-тай хамтран “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал” сэдэвт чанарын сургалт зохион байгуулсан. Сургалтад алба тасгуудын чанарын багийн ахлагч- 23 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>2. 2022 оны 03 дугаар сарын 04-ны өдөр "Сэтгэцийн эрүүл мэнд болон стресс тайлах" сэдэвт сургалтыг СЭМҮТ-ийн сэтгэл зүйч Б.Ариунцацрал хийж нийт 32 ажилтныг сургалтад хамруулсан.<br>3. 2022 оны 06-р сарын 10 өдөр Эрүүл мэндийн чанарын холбооны гишүүн Ш.Нармандах “Байгууллагын соёл” сургалтыг тасаг албадын чанарын багийн нийт 35 гишүүдэд орсон бөгөөд дээрх гишүүд бусад ажилчдад сургалтыг 3-р улирлаас орохоор төлөвлөж байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | <br>4. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ёс зүйг сайжруулах зорилгоор 2022 оны 06 сарын 15-нд ХТС-ийн захирал, НЭМГ-ын Ёс зүйн хорооны дарга, зөвлөгч багш Б.Одгэрэл-ыг урьж "Байгууллагын шинэ соёл" сэдвээр сургалтыг зохион байгуулсан ба сургалтад 44 ажилтан, 13 резидент эмч нар хамрагдлаа.<br><br><br><br>5. Ёс зүйн салбар хорооны самбарыг поликлиникийн тасгийн цахим бүртгэлийн хэсэгт байршуулан үйлчлүүлэгчдэд ёс зүйн холбогдол бүхий мэдээ мэдээлэл, үйл ажиллагааны талаар нийт 5 удаагийн мэдээ, мэдээллийг шинэчлэн байршуулсан.<br>6. 2022 оны байдлаар Ес зүйн хороонд иргэний нийт 2 өргөдөл гомдол ирсэн ба тухайн ьус хорооноос иргэдтэй | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | холбогдож эвлэрүүлэн зуучилж өгч гомдлыг шийдвэрлэсэн. | |
| 35. | 4.3.2 | МУТЖҮЧ-5.4.3. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ёс зүйн сургалтад хамруулна. | - | Сургалтын тайлан | Ажилчид ёс зүйн сургалтад 100 хувь хамрагдсан байна. | Жилийн турш | АӨСҮТөвийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны 2022 оны төлөвлөгөөг салбар хорооны даргаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. 2022 оны Ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор ёс зүйн хорооны гишүүд эмч, сувилагч, асрагч, захиргаа, аж ахуйн ажилтнуудад төлөвлөгөөний дагуу нийт 10 удаагийн сургалтыг давхардсан тоогоор 354 ажилтанд амжилттай зохион байгуулсан. Үүнд:<br>1. Ёс зүйн хорооны дарга Б.Баярмаа “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эмч, мэргэжилтэн үйлчлүүлэгчийн харилцаа” сэдвээр 96 резидент эмч, эмч, сувилагч тусгай мэргэжилтэн, ажилтнуудад сургалт хийсэн.<br>2. 2022 оны 03 сарын 03-нд эмч нарын яриан дээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд ёс зүйн таван зарчим, харилцаа болон хувцаслалтын хэм хэмжээг баримталж ажиллах мэдлэгийг сэргээх зорилгоор АӨСҮТөвийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны гишүүн Г.Баянжаргал Эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн үйл ажиллагаандаа баримтлах харилцаа, хандлага, ёс суртахууны хэм хэмжээ ЭМС-ын А/406 тоот тушаалыг хавсралт “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”, ЭМС-ын 189 тоот тушаал “Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүр | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажлын байранд дагаж мөрдөх журам” сэдвээр 26 эмч, эм зүйч нар сургалтад хамрагдсан.<br> <br>3. Ёс зүйн салбар хорооноос 2022 оны 03 сард АӨСҮТөвийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны дарга Б.Баярмаа “Эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн үйл ажиллагаандаа баримтлах харилцаа, хандлага, ёс суртахууны хэм хэмжээ ЭМС-ын А/406 тоот тушаалыг хавсралт “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”, ЭМС-ын 189 тоот тушаал “Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүр ажлын байранд дагаж мөрдөх журам” сэдвүүдээр 1-р дамжааны 16 резидент их эмч нарт лекц уншсан.<br>4. 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр ХНАД ёс зүйн хорооны нарийн бичиг Б.Пүрэвцэцэг “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харьцаа хандлага” сэдвээр 8 шинэ ажилтанд чиглүүлэх сургалт явуулсан.<br>5. 2022 оны 5 дугаар сарын 01-ны өдөр ёс зүйн хорооны гишүүн, хүүхдийн тасгийн ахлах сувилагч Х.Эрдэнэтуяа “Ёс зүйн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | харьцаа хандлага”-ын сургалтыг 28 сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдсан.<br>6. 2022 оны 06 дугаар сарын 30 АӨСҮТөвийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооноос ХНДА, ЭМЁЗСХорооны нарийн бичиг Б.Пүрэвцэцэг “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын журам”, “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороонд ирүүлсэн өргөдөл гомдол, шийдвэрлэх журам”, ”Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн ёс зүйн хэм хэмжээ” сэдвээр сургалт хийж 17 асрагч, дэмжих үйлчилгээний 10 ажилтан нийт 27 ажилтан хамрагдсан.<br><br>7. 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Ёс зүйн хорооны гишүүн их эмч Г.Баянжаргал 189-р тушаал, Эрүүл мэндийн сайдын А/406 дугаар тушаал “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ийг нийт 29 эмч, эм зүйч нарт эмч нарт танилцуулж сургалт зохион байгуулсан. | |
| *Зорилт 4.4. Хүний нөөцийн нийгмийн баталгааг сайжруулах* | | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 36. | 4.4.1 | МУТЖҮЧ-2.2.8, ЗГҮАХ-2.1.9. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | 5 /улсын төсөв/ | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь байна. | Жилийн турш | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах төлөвлөгөөний хүрээнд нийт 28 ажлыг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:<br>1. Засгийн газрын 2022 оны 03-р сарын 09-ны өдрийн 107 дугаар тогтоолын дагуу 77 ажилтны цалинг албан тушаалын зэрэглэлийг цалингийн доод жишигт хүргэж 2022 оны 03-р сарын 01 өдрөөс олгож эхэлсэн. 5 ажилтны цалингийн шатлалыг 2022-03-01 өдрөөс өмнө нэмэгдүүлсэн. Нийт 86 ажилтны үндсэн цалин 20,000-110,000 нэмэгдсэн.<br>2. 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн Б/177 дугаар тушаалаар нийт албан хаагчдын албан тушаалын үндсэн цалинг 10-20 хувиар дахин нэмэгдүүлсэн.<br>3. Хөдөлмөрийн дотоод журамд клиникийн профессор, магистр, төрөлжсөн нарийн мэргэжлийн нэмэгдлийг сарын үндсэн цалингийн 5-10 хувь, арьсны идээт болон бусад халдварын эрсдэлтэй өвчтөнд сувилахуйн гардан тусламж үйлчилгээг үзүүлдэг сувилагч, туслах сувилагч нарт 10 хувийн халдварын нөхцөлийн нэмэгдлийг өгөхөөр нэмэлтээр тусган ажилласан байна. Мөн урамшуулал, олговрын хэмжээг нэмэгдүүлсэн байна.<br>4. Тайлант оны хугацаанд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг эмнэлгийн ажилтан 4, их эмч 2, сувилагч 3, лаборант 2, асрагч 2, ариутгагч 1 зэрэг нийт 14 эмч эмнэлгийн ажилтанд 5-20 хувиар шинээр тооцон олгож эхэлсэн байна. Мөн зэргийн нэмэгдлийг арьс судлалаар Н.Энхжаргал, М.Амаржаргал, сувилахуйгаар Х.Эрдэнэтуяа, Б.Оюунтуяа нарт 15 хувиар тооцон олгож эхэлсэн байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 5. Э.Мөнхгэрэл,Б.Дэлгэрмөрөн,Д.Чанцалдулам, Б.Оюунтуяа нарт ур чадварыг нэмэгдлийг 25 хувь, Д.Дэлгэрмөрөн, Н.Оюунтуяа, З.Цэцэгмаа нарт хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл 10 хувь, Н.Билгүүнд хариуцлагын нэмэгдэл, Б.Жавзандуламд эд хариуцагчийн нэмэгдлийг 10 хувиар тус тус олгож эхэлсэн байна.<br>6. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдэд 10-20 хувь, Ёс зүйн хорооны дарга, нарийн бичигт 20 хувийн нэмэгдэл олгож байна. Мөн ковидын үеэр дайчлагдан ажилласан эмч эмнэлгийн ажилчдын нэмэгдлийг зохих журмын дагуу олгон ажилласан байна.<br>7. Нийт 14 албан хаагчдад хавсран гүйцэтгэсний нэмэгдэл сарын үндсэн цалингийн 20-40 хувийг олгож 4 ажилтныг хавсран гүйцэтгэсэн ажлаас чөлөөлсөн байна.<br>8. Ахмад настан 2, эмч эмнэлгийн ажилтан 13 нийт 15 хүнд 4,700,000 төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон байна.<br>9. Олон улсын ахмадын баярыг тохиолдуулан тус төвөөс өндөр насны тэтгэвэрт гарсан 117 ахмадад нийт 3,510,000 /гурван сая таван зуун арван мянга/ төгрөгийн тэтгэмжийг олгосон байна.<br>10. Төвийн Хөдөлмөрийн дотоод журмын дагуу 2022 оны тайлант 30 эмч эмнэлгийн ажилчдад 2 хоногоос 3 сар хүртэлх хугацаагаар цалинтай чөлөө, 18 эмч, эмнэлгийн ажилтанд 2 хоногоос 1 сар хүртэлх цалингүй чөлөөлж олгосон байна. Мөн эцгийн чөлөөг 10 хоногоор 3 ажилтан олгосон байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 11. Хүүхэд асрах чөлөөг 10 эмч, эмнэлгийн ажилтанд олгосон.<br>12. Байгууллагын нийт 152 эмч, эмнэлгийн ажилчдад халдвараас сэргийлэх, аюулгүй байдал, эрсдэлийг бууруулах зорилгоор нийт 41,975 ширхэг маскийг давхардсан тоогоор, нэг удаагийн халатыг 1120 ширхэг олгосон.<br>13. 2022 онд 30 ажилтанд 3,131,000 төгрөгийн ажлын хувцсаар хангасан бөгөөд цахим бүртгэл, харуул хамгаалалт аж ахуйн албаны ажилчдад 3-р улиралд олгохоор төлөвлөж байна.<br>14. Арьс, харшлын өвчтэй 8 ажилтан хэвтэн эмчлүүлсэн бөгөөд, оношилгоо, шинжилгээнд 50 ажилтан, гэр бүлийн 30 гишүүн хамрагдан эмнэлгийн тусламж үйлчилгээг авсан байна.<br>15. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгасан “Эрүүл чийрэг хүн”, “Эрүүл идэвхтэй амьдрал” арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн сайдын санаачилгаар 2022 оны 6 дугаар сарыг “Хөдөлгөөний ач холбогдлыг сурталчлах сар” болгон зарлан Эрүүл мэндийн салбарын аварга шалгаруулах "Цагаан нөмрөгтнүүд" 2022 спортын арга хэмжээ 2022 оны 06 дугаар сарын 24, 25, 26-ны өдрүүдэд спортын нөхөрсөг тэмцээнд сагсан бөмбөг, гар бөмбөг, шатар, ширээний теннис, буухиа тэмцээн, дартс гэсэн 6 төрлөөр оролцсон бөгөөд АӨСҮТ-н клиникийн 1-р тасгийн их эмч С.Солонго шатрын тэмцээнд II-р байр эзлэв. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |  <br>16. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум” мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж 2022-05-15 өдөр Налайх дүүргийн Цэцэрлэгт хүрээлэнд Буйлс шилмүүст мод тарьсан. Экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, хамгаалах үйлсэд гар бие оролцсон.<br> <br>17. Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа “Эрүүл мэндийнхээ төлөө алхангаа ярилцъя” алхалтын арга хэмжээнд дэмжин оролцсон ДЭМБ-ын Монголд дах суурин төлөөлөгч Сергей Диордица, эрүүл мэнд, биеийн тамир спортын салбарынхан оролцлоо. Эрүүл мэндийн салбарынхан "Алхангаа ярилцъя" арга хэмжээг зохион байгуулагдлаа. Эрүүл мэндийн яам 2017 оноос ДЭМБ-ын “Walk the Talk” хөдөлгөөнд нэгдэн жил бүр хүн амын дунд | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эрүүл амьдралын хэв маяг, алхалтын ач холбогдлыг сурталчлах ажилд оролцсон. ЭМЯ-ны сайдын санаачилгаар зохион байгуулагдсан “Алхангаа - ярилцъя” аяны хүрээнд үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 2022.06.11-ний өдөр төвийн 30 ажилтан оролцсон.<br><br><br><br>18. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгасан “Эрүүл чийрэг хүн”, “Эрүүл идэвхтэй амьдрал” арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн сайдын санаачилгаар 2022 оны 6 дугаар сарыг “Хөдөлгөөний ач холбогдлыг сурталчлах сар” болгосонтой холбогдуулан 2022 оны 6 дугаар сар 18-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд “Дугуйн аялал-2022” Арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд тус төвийн лабораторийн тасгийн их эмч Б.Сүхболд, аж ахуйн тасгийн жолооч Б.Пүрэвбаяр нар идэвхтэй хамрагдлаа. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | <br>19. Ковид-19 цар тахал буурсантай холбогдуулан 2022 оны 03-р сараас эхлэн 7 хоног бүр Богд, Чингэлтэй хайрхан, Зүрх ууланд хамт олон, тасаг нэгжээрээ алхаж зохион байгуулж байна. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газартай 2022-06-10 өдөр хамтран ажиллах гэрээ байгуулж 7 хоногт 1 удаа сагсан бөмбөг, гар бөмбөг тоглох, биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулж байна.<br> <br>15. Зохистой хооллолт “өглөөний цай” арга хэмжээг 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан цаашид уламжлалт болгон зохион байгуулж байна. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |  <br>16. Байгууллагын эмч, эмнэлгийн ажилчдын нийгмийн хамгааллын чиглэлийн судалгааг 2022 оны 04-р сард 10 чиглэлээр, нарийвчилсан 20 асуумжаар авсан. Дээрх судалгаагаар нийт өрх толгойлсон 16 ажилтан, эмзэг ядуу 12 ажилтан, айлын хашаанд 5 ажилтан, түрээсийн байр, байшинд 15 ажилтан, гэрт 13 ажилтан, 6-8%-ийн зээлтэй 20 ажилтан, цалингийн зээлтэй 110 ажилтан гэх мэт нийгмийн хамгааллын судалгаа гарган дэмжлэгт удирдлагаар хангах талаар үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна. Гүйцэтгэх захирлын 2022-03-21 өдрийн Б/69, 2022-04-07 өдрийн Б/86, 2022-05-02 өдрийн Б102 тоот тушаалаар 3 ажилтанд буцалтгүй тусламж 900,000 төгрөгийг олгосон байна.<br>17. "Харилцан хүндэтгэе" аяны хүрээнд АӨСҮТөвийн их эмч Д.Сүхболд, Б.Энхсайхан нар жендерийн талаарх өөрсдийн үзэл бодлоо илэрхийлж тус аянд нэгдэж байна.<br>18. Жил бүрийн 6 дугаар сарын 1-ны өдрийг хүүхдийн эрхийг хамгаалах өдөр болгон тэмдэглэн ирсэн. Энэхүү өдрийн хүрээнд АӨСҮТ-н Хүүхдийн тасгаас "Бидний баяр" гар зургийн уралдаан, "Захидлын | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | уралдааныг амжилттай зохион байгуулж тэмцээнд оролцсон шагналт байрууд болон бүх бяцхан хүүхдүүдээ урамшуулсан.<br>19. Байгууллагын дотоод журамд ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоох, хүлээлгэх хариуцлагын талаар оруулж мөрдөж байна. Байгууллагын эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэхэд удирдлагын баг, Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, ЭМТҮЧА, ХНА, Сургалтын алба, клиникийн тасгууд хамтарч 2022 онд нийт 15 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа.<br>20. 2022-04-26-ны өдөр олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан "Гурван үеийн уулзалт" зохион байгуулсан.<br><br>22. 2022-05-3-ны олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан “Сувилагчаа алдаршуулъя” сэдэвт уулзалтыг зохион байгуулж ахмад сувилагч Ш.Янжин, Б.Отгон тус төвийн эрчимт эмчилгээ яаралтай тусламжийн тасгийн ахлах | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сувилагч Н.Оюунгэрэл нарыг урин хүндэтгэл үзүүлж, мэдлэг, ажлын туршлагаас нь хуваалцан шинэ залуу сувилагч нартаа сувилахуйн мэргэжлийн үнэ цэнэ, багаар хамтран ажиллах, нэг байгууллагад олон жил ажиллахын талаар сувилагч тусгай мэргэжилтнүүдтэй ярилцлага зохион байгуулсан.<br>23. Хөдөлмөрийн шинэчилсэн хуультай холбоотой байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулан 2022 оны 01 дүгээр сарын 03 өдөр гүйцэтгэх захирлын А/01 тушаалаар батлан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөнгөлөлттэй эдлэх заалтыг нэмж оруулан хэрэгжүүлж байна. Арьс, харшлын өвчтэй 8 ажилтан хэвтэн эмчлүүлсэн бөгөөд, оношилгоо, шинжилгээнд 50 ажилтан, гэр бүлийн 30 гишүүн хамрагдан эмнэлгийн тусламж үйлчилгээг авсан байна.<br>24. Лабораторийн тасгийн ариутгагч Д.Уранцэцэг эрүүл мэндийн шалтгаанаар БНСУ-ын "Илсан эмэгтэйчүүд, хүүхдийн эмнэлэг"-т 2022 оны 07 дугаар сард мэс засалд орох, цаашид тодорхой хугацаагаар эмчилгээ хийлгэх шаардлагатай болсон тул нийт эмч, эмнэлгийн ажилчид, хамт олны дунд хандивын аянд зарласан бөгөөд энэхүү аянд нийт 95 эмч, эмнэлгийн ажилчид нэгдэн 2,075,000 төгрөгийн хандив цуглуулан өгсөн.<br>25. “Хайрыг түгээе” сайн үйлсийн аяны хүрээнд хамт олноос цуглуулсан зүйлсийг СБД–ийн 11-р хороонд амьдардаг хүнсний талон авдаггүй, олон хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэй, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өөрийн гэсэн хүүхэдгүй ганц бие өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй өрх, эхнэр нөхөр 2-уулаа хөгжлийн бэрхшээлтэй, аав ээж нь архины хамааралтай хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, асарч хамгаалдаг хүү нь цэрэгт явсан ганц бие эмэгтэй, хүүхдийн тасгийн асрагчийн гэр нь шатсан жирэмсэн эгчийн гэр бүл зэрэг нийт 11 гэр бүлд хандив өгсөн байна.<br>26. Хоол үйлдвэрлэлийн тасгаас “Урлаг эрүүл мэнд” сэдэвт хөтөлбөр бүх эмч , ажилтан, алба хаагч нарын дунд зохион байгуулсан байна.<br>27. Эрүүл мэндийн салбарын "Цагаан нөмрөгтнүүд" спортын нөхөрсөг 6 төрөлт тэмцээнд АӨСҮТ-н клиникийн 1-р тасгийн их эмч С.Солонго шатрын тэмцээнд II-р байр эзэлж амжилттай оролцсон<br><br>28. АӨСҮТөвийн ҮЭХ-оос гар бөмбөг, сагсан бөмбөг, дартс, шатар, теннис зэрэг 5 төрлийн спортын уралдаан тэмцээнийг амжилттай зохион байгуулсан.<br> | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 37. | 4.4.2 | МУТЖҮЧ-3.2. Ажилчдыг орон сууцтай болгох орон сууцны зээлд хамруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ. | - | Орон сууцны зээлд хамруулсан ажилтны тоо | 3 эмнэлгийн ажилтан орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна. | 3,4 дүгээр улирал | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сарын хүрээнд 9 ажилтанд нийт 75 сая төгрөгийн батламжийг гардуулсан.<br>➢ Орон сууцны урьдчилгаа 20 сая төгрөгийг 2 ажилтанд: Т.Мөнхцацрал /аж ахуйн албаны дарга/, П.Минжбадрах /ургамал зүйч/<br>➢ Хашаа байшин урьдчилгаа 10 сая төгрөгийг 1 ажилтанд: /Б.Олз-Ундрах тогооч/<br>➢ Орон сууцны ипотек зээлийн хөнгөлөлт 5 сая төгрөгийг 2 ажилтанд: Ж.Энхжаргал /лабораторийн тасгийн эрхлэгч/, А. Сэлэнгэ /нягтлан бодогч/<br>➢ Монгол гэрийг 4 ажилтанд: Д.Эрхэмбаяр /хөтөч/, Д.Цэнгэлсүрэн /асрагч/, Д.Сарангэрэл /туслах сувилагч/ Н.Ариунтөгс /цахим бүртгэгч/<br><br>Хас банк хамтын ажиллагааны хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 22-ны өдөр байгууллагын тасаг, албадын 95 эмч, эмнэлгийн ажилчдад ипотекийн 6%-н зээл, цалингийн зээл, бусад зээлийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хийснээр ипотекийн 6 хувийн хөнгөлөлттэй зээлд 1 ажилтан хамрагдсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 38. | 4.4.3 | МУТЖҮЧ-2.2.8, ЗГҮАХ-2.1.9. Эмч, эмнэлгийн ажилтны өвчлөлийн судалгаа гаргах, халдварт өртөхөөс сэргийлнэ. | - | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан ажилчдын хувь | Эмч, эмнэлгийн ажилчид 100 хувь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна. | Жилийн турш | Ажилчдын эмчтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадвар алдалтын групптэй, архаг суурь өвчтэй ажилчдын судалгааг гаргасан. Дээрх судалгаагаар төвийн хэмжээнд 6 ажилтан 50-90%-н хөдөлмөрийн чадвар алдалттай байна. Ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих, халдварт өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч ажиллалаа:<br>➢ Дархлаа сэргээх нэмэлт тунгийн вакцинжуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх, халдвараас сэргийлэх дэглэмийг сурталчлах зорилгоор 2022 оны 1 дүгээр сард нэмэлт 3-р тунд нийт-14, 4-р тунд нийт-12 ажилчид хамрагдсан байна.<br>➢ Нийт 97 ажилтанд элэгний B,C илрүүлэх шинжилгээг хийхэд 4 ажилтанд C вирус эерэг, 1 сул эерэг, 2 ажилтанд B вирус эерэг гарсан<br>➢ B гепатитын эсрэг вакцинд нийт 49 эмч эмнэлгийн ажилтан хамрагдсан байна. Үүнээс 1-р тунд 49, 2-р тунд 14, 3-р тунд 7, ажилтан хамрагдсан.<br>➢ B вирусийн дархлаа тогтцыг 95 ажилтанд хийхэд 24 ажилтан бүрэн дархлаа тогтсон, 37 хүн дархлаа тогтоогүй, 34 ажилтан вакцины нэмэлт тунд хамруулсан.<br> | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ➢ Ажилчдыг эмэгтэйчүүд, дотор, шинжилгээний багцад хамруулах зорилгоор Чин-баян ЭХНТөвтэй хамтран умайн хүзүүний эсийн шинжилгээ болон хеликобактерийн шинжилгээнд нийт ажилчид хамрагдсан байна.<br>➢ “Эрчүүдийн эрүүл мэндийг хамгаалахад эмэгтэйчүүдийн оролцоо” арга хэмжээний хүрээнд байгууллагын эрэгтэй 15 ажилтанд эхо, коагулограммын шинжилгээнд хамруулж зөвлөгөө өгсөн.<br>➢ Эмнэлгийн ажилчдаас 81 ажилтан дүрс оношилгооны шинжилгээнд хамрагдсан бөгөөд үүнээс эрэгтэй ажилтан-19, эмэгтэй ажилтан-62 байна.<br>➢ Гепатит В болон С вирусийг нийт 69 ажилтанд үзүүлсэн. 2022 онд нийт ажилчдын 8.6% буюу 12 ажилтан гепатит С вирустэй байна. 3.6% буюу 5 ажилтан В вирустэй байна. Гепатит В вирусийн дархлаа тогтцыг 68 ажилтанд үзсэн.<br>➢ 2022 оны 11 сарын 14-17-ны өдрүүдэд нүдний урьдчилан сэргийлэх үзлэгээр нийт 132 ажилтан хамруулсан. Нүдний урьдчилсан сэргийлэх үзлэгээр нүдний хол ба ойрын харааны түвшнийг тогтоох, гэрлийн хугарлын гажгийг тодорхойлох, нүдний угийг тодорхойлох, шаардлагатай тохиолдолд хүүхэн хараа өргөсгөгч ашиглах зэрэг үзлэгүүд хийгдсэн. Нүдний үзлэгийн үр дүнд холын харалган-57, наснаас хамаарсан ойрын харалган-9, төрөлхийн + хараатай ойрын харалган-9, цилиндр хараатай-10, нүд хуурайших хам шинжтэй-5, торлогийн өвчнүүд-4, болрын эмгэгүүд-4, сул хараатай-1 онош бүрд тулгуурлан зөвлөгөө өгсөн. Цаашид | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажилчдын нүдний урьдчилан сэргийлэх үзлэгийг жил бүр ялангуяа 40-аас дээш насныханд ойр болон холын харааг тогтмол шалгуулж байх хэрэгтэй байна.<br>➢ Хүүхдийн тасаг, лаборатори, эм зүйн тасгийн 29 ажилтныг цээжний рентгенд харуулсан. Рентгенээр 1 ажилтан шохойжилттой бусад ажилчид хэвийн гарсан байна.<br>➢ АӨСҮТ-ийн ажилчдын MRSA илрүүлэх шинжилгээг 73 ажилтанд хийснээс 23 ажилтан MRSA халдвар илэрсэн байна. 23 ажилтанд бактериоцин тосыг тарааж өгсөн. Ажилчдын эргэн тойрон болон өрөө тасалгаанд ариутгал хийлгүүлж, жавелион-0,06%-ийн уусмалаар арчиж арга хэмжээ авсан.<br> <br>➢ 2022 оны 10 сарын19-ны А/512 тоот тушаалын дагуу 2022 оны 10 сарын 27-ны өдөр “Томуугаас сэргийлэх” уриан дор И.Мөнхзаяа ажилчдын эмч, Б.Батцэцэг ахлах сувилагч нар нийт 70 эмч эмнэлгийн ажилтныг томуугийн эсрэг дархлаажуулалтад хамруулсан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |  <br>➢ Эмнэлгийн дадлагажигч буюу резидент эмч нарыг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан. Үүнд:<br>- 2022 оны 11сарын14, 17 өдрүүдэд нүдний урьдчилан сэргийлэх үзлэгээр нийт 18 резидент эмч хамрагдсан байна.<br>- Гепатит в болон с вирусийн шинжилгээнд 11 резидент эмчийг хамруулсан.<br>- MRSA илрүүлэх шинжилгээнд 5 резидент эмч хамрагдсан байна. MRSA халдвар илрээгүй байна.<br>- Томуугийн эсрэг вакцинд нийт 7 резидент эмч хамрагдсан байна.<br>➢ Ахмадын эрүүл мэндийг дэмжих сарын хүрээнд Геронтологийн үндэсний төвтэй хамтран 2022 оны 10-р сарын 28-ны өдөр төвийн ахмадууддаа урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо хийн, эрүүл мэндийн зөвлөгөө өгч ажиллаа. Арьс харшлын эмчийн үзлэгт 18, зүрхний эмчийн үзлэг ба зүрхний цахилгаан бичлэгт тус бүр 17, хэвлийн хэт авиан шинжилгээнд 19, сэргээн засах эмчийн үзлэгт 16, ясны сийрэгжилт тодорхойлох шинжилгээнд 15 ахмад тус тус хамрагдаж, давхардсан тоогоор 84 ахмад настан үзлэг, шинжилгээнд хамрагдсан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |   | |
| ЗОРИЛГО 5. ДЭВШИЛТЭТ ШИНЭ ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЖ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖӨӨР БҮРЭН ХАНГАХ | | | | | | | | |
| *Зорилт 5.1. Хүн амын арьсны эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд суурилсан дэвшилтэт технологийг нэвтрүүлэх* | | | | | | | | |
| 39. | 5.1.1 | МУТЖҮЧ-2.2.3. Арьс харшлын эмчилгээнд чонон хөрвөс, атопийн дерматит өвчний үед бай эмчилгээг шинээр нэвтрүүлэх судалгааг хийнэ /эмийн компанийг судлах/ | 10 /улсын төсөв/ | Үйлчлүүл эгчийн тоо | Шинээр бай эмчилгээг практикт амжилттай нэвтрүүлж, хамрагдсан үйлчлүүлэгчийн эмчилгээний үр дүнг тооцсон байна. | Жилдээ | Арьс харшлын эмчилгээнд чонон хөрвөс, атопийн дерматит өвчний үед бай эмчилгээг шинээр нэвтрүүлэхтэй холбогдуулан IgE хориглогч бай эмчилгээ болох Omalizumab тарилгыг Новартис эмийн компанитай хамтран ажиллаж санал өгч, Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдэн албан ёсоор эмчилгээнд хэрэглэх боломж бүрдээд байна. Үүний тул дараах зорилтыг тавьж ажилласан. Үүнд:<br>1. IgE-н тунг үзэх, цусанд иммуннологийн шинжилгээг жилд 2028 хүнд хийсэн.<br>2. IgE-н титр цусанд 700 u/l-ээс дээш тохиолдолд IgE хориглогч бай эмчилгээг хийх оруулах шалгуурт авах (10% хамрагдаж байна)<br>3. Өмнө хийгдсэн кортикостеройд болон антигистамин, интерлейкин хориглогч эмчилгээнд үр дүнгүй байгаа эсэхийг тодорхойлох. (3-6 сар)<br>4. Үйлчлүүлэгчийг шинээр нэвтрүүлэх эмчилгээнд хамрагдах хүсэлт, төлбөр төлөх боломжийг харгалзах байдлаар зохион байгуулсан | 100 |
| 40. | 5.1.2 | МУТЖҮЧ-2.2.3. Хүчилтөрөгчийн озон эмчилгээг арьсны эмгэгийн | 10 /улсын төсөв/ | Үйлчлүүл эгчийн тоо | Хүчилтөрөгчийн озон эмчилгээг | Жилдээ | Арьс харшлын зарим өвчний үед хэрэглэгддэг Озон эмчилгээг тусламж үйлчилгээнд шинээр нэвтрүүлэхээр озон үүсгэгч аппарат худалдан авах авах ажлын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | болон харшлын өвчний эмчилгээний практикт нэвтрүүлнэ. | | | практикт амжилттай нэвтрүүлж, үйлчлүүлэгчийн эмчилгээний үр дүнг тооцсон байна. | | хэсгийг 2022 оны 08 дугаар сард байгуулж нээлттэй тендер зарлаж сонгон шалгаруулалтыг зохион байгуулж 12 сарын эхээр хүлээн авч тусламж үйлчилгээнд нэвтрүүлэхэд бэлэн болоод байна. | |
| 41. | 5.1.3 | ЗГҮАХ-2.1.4. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. /лаборатори, эмчилгээний гоо засал, нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ/ | 135 /улсын төсөв/ | Төлөвлөсөн тоног төхөөрөмжийн хангалтын хувь | Лаборатори, эмчилгээний гоо засал, нөхөн сэргээх тусламж, үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмжөөр 30 хувь хангасан байна. | Жилдээ | Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай дараах тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.<br>➢ Лабораторийн тасагт коагулограммын аппарат<br>➢ Өдрийн эмчилгээний кабинет болон лабораторийн тасагт нийт 2 ширхэг центрифуг .<br>➢ Эмчилгээний гоо засал нөхөн сэргээх тасагт арьс өвчний үед хэрэглэгддэг нүүрсхүчлийн хийн лазер аппарат<br>➢ Озон үүсгэгч аппарат<br>  | 100 |
| *Зорилт 5.2. Мэдээллийн технологийг бүрэн нэвтрүүлж цахим эмнэлэгт шилжих* | | | | | | | |
| 42. | 5.2.1 | ЗГҮАХ-2.1.6. Байгууллагын хүний нөөцийн төлөвлөлтийн /ERP/ цахим системийг бүрэн нэвтрүүлнэ. | - | Хүний нөөцийн цахим системийн төлөвлөлтийн | Байгууллагын хүний нөөцийн төлөвлөлтийн /ERP/ цахим систем бүрэн нэвтэрсэн байна. | Жилийн турш | Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн нэгдсэн системд ажилтны үндсэн мэдээлэл, ажил эрхлэлт, нэмэгдэл зэргийг мэдээллийн санд 2022 оны 01 сард багтаан оруулахтай холбоотой Төрийн албаны зөвлөлөөс ээлжит сургалтуудыг хийсэн. Дээрх сургалтын дараа байгууллагын 152 ажилтан, 6 ТУЗ-ын гишүүн, 36 резидент | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэрэгжилтийн хувь | | | эмч, хүүхэд асрах чөлөөтэй 18 ажилтны мэдээллийг шинэчлэн программд оруулан Төрийн алба хаасан хугацаа, улсад ажилласан жилийг цахимжуулах үйл ажиллагааг зохион байгуулсан.    | |
| 43. | 5.2.2 | БДХСТ-7.1.1.3. Мэдээлэл технологийн компьютер, серверийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ. | 20 /улсын төсөв/ | Нэмэгдүүлсэн серверийн үйлчилгээ | Мэдээлэл технологийн серверийн хүчин чадлыг нэмэгдүүлж бүрэн шинэчилсэн байна. | Жилийн турш | ➢ Тус төвийн эмч нарийн компьютерт SSD 120GB хард диск суурилуулж, хард дискэнд windows 10pro 64bit үйлдлийн систем суулган e-health болон хэрэглээний програм office 2016 суулган хуучин hdd хард диск дээрх мэдээллийг зөөврийн хад диск дээр хуулан тухайн компьютеруудыг форматлаж хуулсан мэдээллүүдээ display, download, document, D-disk гэх мэт хуучин байсан хэсэгт нь байршуулан хэвийн ажиллах нөхцөлөөр хангасан<br>➢ Эрүүл мэндийн яамны дэмжлэгээр АӨСҮТөвд Dell Optiplex 5090FF марктай 15 процессор Dell DP/N:0xtw00 марктай 15 дэлгэц ирснийг Амбулаторийн үзлэгт зориулан тус иж бүрэн компьютерыг 15 эмчид шинээр суурилуулж E-health программ, хэрэглээний программ болон үзлэгт хэрэглэгдэх ZKFinger SDK хурууны хээ уншигч төхөөрөмжийг суурилуулж install-ийг уншуулан эмч ашиглахад хэвийн нөхцөлөөр хангасан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ➢ Амбулаторийн бусад Ram диск 4GB санах ойн хүчин чадалтай компьютерын хурдыг Transcent DDR 8gb шуурхай санах ойн диск нэмэлтээр тавьж мэдээллийн хурдыг сайжруулан гацалтгүй болгосон<br>➢ E-health программ, хэрэглээний программ болон үзлэгт хэрэглэгдэх ZKFinger SDK хурууны хээ уншигч төхөөрөмжийг суурилуулж install-ийг уншуулан эмч ашиглахад хэвийн нөхцөлөөр хангасан.<br>➢ Хэмнэлтийн хуультай холбоотой серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх төсвийг ирэх онд батлуулахаар төлөвлөж байна. | |
| ЗОРИЛГО 6. БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ ОНОВЧТОЙ БОЛГОЖ, САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАЖ АЖИЛЛАХ | | | | | | | | |
| *Зорилт 6.1. Хагас бие даасан засаглалыг хөгжүүлэх, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэх* | | | | | | | | |
| 44. | 6.1.1 | МУТЖҮЧ-2.2.5. Төлөөлөн удирдах зөвлөл жилийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлж ажиллана. | 17 /улсын төсөв/ | Хууль, дүрэм, журмын хэрэгжилт | Хууль дүрэм, журмын дагуу ажиллаж, төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлсэн байна. | Жилийн турш | 2022 оны байдлаар тус төвийн Төлөөлөн удирдах зөвлөл нийт 6 удаа хуралдаж 16 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн бөгөөд хурлаар нийт 11 тогтоолыг баталсан. Үүнд:<br>➢ ТУЗ-ийн нарийн бичгийн даргын жирэмсний болон амаржсаны амралт олгох,<br>➢ нарийн бичгийн даргын түр орлон гүйцэтгэгчийг томилох,<br>➢ гүйцэтгэх захирлын 2022 оны ажлын үр дүн, төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан “Контракт”-ын биелэлтийг дүгнэх урамшуулал олгох тухай,<br>➢ улирлын ажлын гүйцэтгэлийн урамшуулал олгох журам /KPI/ батлах тухай,<br>➢ бүтэц орон тоо баталсан тогтоолыг хүчингүй болгох,<br>➢ төвийн ажилчдын үндсэн цалинг нэмэгдүүлэх тухай, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ➢ 2022 оны төсвийн хуваарийн өөрчлөлтийг гүйцэтгэлийн санхүүжилттэй уялдуулах замаар 3 удаа шинэчлэн батлах зэрэг болно<br>➢ 2022 онд ТУЗ-ийн гишүүн Г.Пүрэвсүрэн өөрчлөгдөн ЭМДЕГ-аас Баярболд томилогдсон<br>➢ ТУЗ-ийн дарга Л.Энхсайхан өөрчлөгдөж эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн дагуу ахмад гишүүн М.Туяа даргын үүргийн түр орлон гүйцэтгэж байна. | |
| 45. | 6.1.2 | МУТЖҮЧ-2.2.5. ЭМДЕГ-тай гэрээ байгуулж хамтарч ажиллана. | - | Гэрээний хэрэгжилтийн хувь | ЭМДЕГ-тай байгуулсан гэрээг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. | Жилийн турш | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай 2022 оны 03 дугаар сарын 11-ны өдөр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авах гэрээг байгуулж нийт 16 төрлийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ, 7 төрлийн амбулаторийн тусламж үйлчилгээ, 8 төрлийн яаралтай тусламж үйлчилгээ болон өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ, өдрийн эмчилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлж ажиллаж байна.<br>2022 оны жилийн эцсийн байдлаар эрүүл мэндийн даатгалын сангаас гэрээний дагуу тусламж үйлчилгээг үзүүлж нийт 2.624,682.548 төгрөг нэхэмжилсэн ба дараах тусламж үйлчилгээг үзүүлж ажилласан:<br>- Амбулаторийн нийт үзлэг - 46865<br>- Яаралтай тусламж-2082<br>- Нийт хэвтэн эмчлүүлэгч-2236<br>- Эрчимт эмчилгээ – 99<br>- Өдрийн эмийн эмчилгээ-241<br>- Сэргээн засахын тусламж үйлчилгээ нийт - 1416<br>- Лабораторийн шинжилгээ-32750 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Ковид-71<br>- Арьс хатгах сорил-3017<br>Өмнөх оны эхний хагас жилтэй харьцуулахад эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 37 хувиар нэмэгдсэн байна.<br>2022 оны 12 сарын 10-ны байдлаар:<br>1. Амбулаторийн үзлэг нийт -82,845<br>2. Хэвтэн эмчлүүлсэн нийт-3866<br>3. Өдрийн эмийн эмчилгээ -480<br>4. Эрчимт эмчилгээ нийт – 179<br>5. Зөвлөх эмч, эмч нарын хамтарсан үзлэгт нийт-153<br>Онош тодруулахаар -78<br>Эмчилгээний заалт авахаар -124<br>Ор хоног сунгахаар -19<br>Комиссын шийдвэр авахаар -1<br>Эрчимт эмчилгээнд шилжүүлэх эсэхийг шийдэхээр -1<br>Онош батлахаар -1<br>Эмнэлгээс гаргах эсэхийг шийдэхээр -1<br>Цаашдын эмчилгээний заалт авахаар -7<br>6. Яаралтай тусламж нийт -4094<br>7. Оношилгоо шинжилгээнд хамрагдсан үйлчлүүлэгч -58,989<br>8. Сэргээн засах эмчилгээнд хамрагдсан -2741 | |
| 46. | 6.1.3 | ЗГҮАХ-1.1.9. Зардлыг бууруулан, хэмнэлтийн горимд шилжих төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ. | - | Хэмнэсэн зардлын хэмжээ | Зардлыг бууруулан, хэмнэлтийн горимд шилжиж ажилласан байна. | Жилийн турш | Хэмнэлтийн тухай хуулийн дагуу санхүүгийн сахилга батыг мөрдүүлж ил тод байдлыг хангаж, үр ашгийг нэмэгдүүлж ажилласан. Цалин хөлс, нэмэгдэл урамшил төлөвлөгөөнөөс 187,458,249 төгрөг буюу -7%, нийгмийн даатгалын шимтгэл 37,515,666 төгрөг буюу -10%, байр ашиглалтай холбоотой зардал 32,815,522 төгрөг буюу -21%, нормын хувцас, зөөлөн эдлэл 7,057,500 төгрөг буюу -47%, багаж, техник хэрэгсэл 105,621,920 төгрөг буюу- | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 70%, тавилга 15,144,400 төгрөг буюу -61%, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл 8,000,000 төгрөг буюу -100%, урсгал засвар 148,326,080 төгрөг буюу -31%, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 30,927,774 төгрөг буюу -33%-н хэмнэлттэй ажилласан байна. | |
| 47. | 6.1.4 | ЗГҮАХ-2.1.7. Оношийн хамааралтай бүлгийн өртгийн жинг тооцож, саналыг ЭМДЕГ-т хүргүүлнэ. | - | Өртгийн тооцоо | Оношийн хамааралтай бүлгийн өртгийн жинг тооцож, саналыг ЭМДЕГ-т хүргүүлсэн байна. | Жилийн турш | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг оношийн хамааралтай бүлгийн жагсаалттай холбоотой нийт 5 удаагийн албан бичгээр нийт давхардсан тоогоор нийт 20 саналыг ЭМДЕГ-т хүргүүлсэн. | 100 |
| 48. | 6.1.5 | МУТЖҮЧ-2.2.8. Дэвшилтэт технологи, шинэ санаа нэвтрүүлэн, үр ашигтай ажилласан эмч, эмнэлгийн ажилтныг урамшуулна. | 5 /өөрийн орлого/ | Шинээр нэвтрүүлсэн дэвшилтэт технологи, олгосон урамшууллын хэмжээ | Дэвшилтэт технологи, шинэ санаа нэвтрүүлэн, үр ашигтай ажилласан эмч, эмнэлгийн ажилтныг урамшуулсан байна. | Жилийн турш | Шинэ санааны өдөрлөгийг 2022 оны 10 дугаар сард амжилттай зохион байгууллаа.<br>➢Багийн төрөлд<br>- ЭЭЯТТ-ийн “Энгийн цэврүүтэлт оноштой хүнд Ритуксимаб эмчилгээг хийсэн нь ” 1-р байранд орж үндсэн цалингийн 40 хувиар<br>- Клиникийн 2-р тасгийн “E-health программ дээр сувилахуйн чиглэлээр гаргасан шинэ санаа” байранд орж үндсэн цалингийн 30 хувиар<br>- Хүүхдийн тасгийн “Бехчет” өвчний эмчилгээнд колхицин эмийг хэрэглэсэн үр дүн 3-р байранд орж үндсэн цалингийн 20 хувиар тус тус шагнуулсан.<br>➢Эмч нарын төрөлд<br>- Поликлиникийн тасгийн их эмч Цогзолын “Харшлын паспорт” 1-р байранд орж үндсэн цалингийн 40 хувиар | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - ЭГЗНСТ-ийн их эмч Д.Сүхболд “Хэт ургалтат сорвижилтийн мэс заслын эмчилгээ (Z plasty)” 2-р байранд орж үнэдсэн цалингийн 30 хувиар<br>➢ Сувилагчийн төрөлд ЭГЗНСТ-ийн туслах сувилагч Сарангэрэл “Усанд ороод гарахдаа түшиж гарах тулгуур мод” 1-р байранд орж үндсэн цалингийн 40 хувиар тус тус шагнууллаа.<br>Үр ашигтай ажилласан нийт 50 эмч, эмнэлгийн ажилтныг урамшуулж ажиллалаа. Үүнд:<br>1. Бусдыгаа манлайлан, үр ашигтай ажилласан нийт 10 тасаг нэгжийн 24 ажилтныг нийт 2.400.000 төгрөгөөр урамшуулсан.<br>2. Н.Оюунгэрэл /ЭЭЯТТасгийн ахлах сувилагч/ “Сонгино”-ын амралтад 5 хоног амрах эрхээр шагнасан.<br>3. Б.Алтантуяа /лабораторийн ахлах зэргийн лаборант/ “Сонгино” амралтад 5 хоног амрах эрхээр шагнасан.<br>4. Б.Батцэцэг /поликлиникийн ахлах сувилагч/ “Цалинтай нэг өдрийн чөлөө”-өөр урамшуулав.<br>5. Ж.Тунгалаг /II тасгийн сувилагч/ “Нөхөн сэргээх үйлчилгээнд 5 хоног үйлчлүүлэх эрхээр шагнуулсан.<br>6. Т.Оюунбилэг /ЭЭЯТТасгийн сувилагч/ “Нөхөн сэргээх үйлчилгээнд 5 хоног үйлчлүүлэх эрхээр шагнасан.<br>7. Х.Одсүрэн /ЭЭЯТТасгийн сувилагч/ 500,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгов.<br>8. Э.Энхцэцэг /Iтасгийн сувилагч/ “500,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгов | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 9. Х.Байгалмаа /II-р тасгийн сувилагч/ - гэр бүлийн зураг авхуулах эрхээр шагнуулсан.<br>10. Өндөр өртөгтэй болон төлбөртэй тусламж, үйлчилгээний журмыг гүйцэтгэх захирлын 2021-06-28 өдрийн А/27 тушаалаар баталсан бөгөөд нийт давхардсан тоогоор 13 эмч, 13,472,500 төгрөгийн /төлбөртэй тусламж үйлчилгээ үзүүлсний эмчид ноогдох хувь/ урамшуулал болгон цалинд олгосон. | |
| *Зорилт 6.2. Хэрэглэгч төвтэй, сэтгэлд шингэсэн үйлчилгээ үзүүлэх* | | | | | | | | | |
| 49. | 6.2.1 | МУУХХБ-2.2.27. Байгууллагын дотоод орчин болон гадна зам талбайг тохижуулж, үйлчлүүлэгчийн тав тухыг хангаж ажиллана. | 557 /улсын төсөв/ | Шинээр тохижуул сан ажил | Байгууллагын дотоод орчин болон гадна зам талбайг тохижуулсан байна. | Жилдээ | ➢ Нийслэлийн хөрөнгө оруулалтын 557.000.000 сая санхүүжилтээр гаднах талбайн 2237мкв авто зогсоолд байгалийн боржин чулууг шигтгэж, 398мкв явган хүний зам тавьж, усны хаялга шинээр гаргаж, 5 ширхэг камер байрлуулж тохижилт үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэлээ. Гадна тохижилт үйлчилгээний үлдсэн ажлыг ирэх жилийн төсөвт суулгахаар төлөвлөж байна.<br><br>➢ Ковидоос болж 2 жилийн хугацаанд засвар үйлчилгээ хийгдээгүй Аварга тосон сувилаллын нийт 13 сувиллын байр, 3 цооног, сүүдрэв, ариун цэврийн 5 өрөөнүүдэд засвар үйлчилгээг засвар үйлчилгээг хийж тохижууллаа. | 10 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |   | |
| 50. | 6.2.2 | БДХСТ-8.1.3.6. Байгууллагын ажлын байрны эмх цэгцийг сайжруулах Японы менежментийн 5S зарчмыг хэвшүүлнэ. | 10 /өөрийн орлого/ | 5S зарчим хэвшсэн байдал | Байгууллагын ажлын байрны эмх, цэгц сайжирч, цэвэр орчин бүрдсэн байна. | Жилийн турш | Ажлын байрны эмх цэгцийг сайжруулах 5S Seiri, Seiron, Seiso зарчмыг тасаг нэгжүүд өдөр тутам хэрэгжүүлж байна.<br>1. Хоёр талт эмийн сан, амбулаторийн хаягжилт, мэдээллийн самбарыг цэгцлэн зохион байгуулсан (Сейрон)<br>   <br>2. Байгууллагын халдвар хамгааллыг сахиж, цэвэр цэмцгэр байдлыг хангаж ажиллаж байна.<br> <br>3. Байгууллагын эмх цэгцтэй байдлыг хангах тал дээр санаачилгатай ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |  <br>4. Тасаг нэгжид хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг сайн ангилан ялгаж, хаяглаж санаачилгатай ажиллаж байна. (Сейри)<br> <br>5. Тасаг нэгжүүд эмийн брошюрын хавтастай болсон.<br> <br>6. Яаралтай тусламжийн ажиглалтын өрөөний тэргэнцрийг сольж, яаралтай хэрэглэгдэх эм, тариа, багаж хэрэгслүүдийг цэгцэлж, хэрэглэхэд хялбар болгосон. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |  <br>7. Хүлээн авахын түлхүүрийн шүүгээг цэгцэлж дугаарлаж, яаралтай үед авахад хялбар болгосон.<br>8. Эмчлүүлэгчийн ариутгасан цагаан хэрэглэлийг иж бүрдлээр нь ангилсан<br>9. Шар бүсийн эмийн савыг сольж, нэршлээр ангилсан.<br><br>10. Овор багатай, хэрэглэхэд хялбар цэвэрлэгээний тэргэнцэр үйлчилгээндээ ашиглаж байна.<br> | |

ТАЙЛАН НЭГТГЭСЭН

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН

ДЭД ЗАХИРАЛ Т.БАЯРМАА

ТАЙЛАН ХЯНАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ц.УРАНЧИМЭГ